


ТАЙЛАН 2020/2021



Хараат бус

Чанар

Үр нөлөө

IRIM судалгааны хүрээлэн



1503 тоот, Pro ONE барилга, Ногоон нуурын гудамж
11-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот



46A/265 Улаанбаатар, Монгол



www.irim.mn



IRIMongolia



[irim_mongolia](https://twitter.com/irim_mongolia)



[irim_mongolia](https://www.instagram.com/irim_mongolia)



+976-7011-7101



contact@irim.mn

ISBN 978-9919-24-538-2

АГУУЛГА

1	Бидний үзүүлдэг үйлчилгээ.....	3
2	Өмнөх үг.....	4
3	Бидний тухай.....	5
4	IRIM тоогоор.....	6
5	2020 оны онцлох үйл явдлын товчоо.....	7
6	2020 онцлох мэдээ.....	9
7	IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төслүүд.....	12
	1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал 2020.....	12
	2. Монголчуудын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа 2020: Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал.....	16
	3. КОВИД-19 цар тахлаас үүдэн хүнс, тэжээлийн дутагдалд орсон эмзэг бүлгийн өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх төсөл.....	18
8	Хэрэгжүүлсэн төслүүд.....	21
	4. Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн эцсийн шатны үнэлгээ.....	21
	5. “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийн үр дүнд суурилсан мониторингийн систем боловсруулах төсөл.....	24
	6. Залуучуудын санал бодлын судалгаа.....	27
	7. “Амьсгалах Эрх” төслийн хэрэгжилтийн үнэлгээ.....	29
	8. КОВИД-19 цар тахлын ААН-үүдэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа.....	33
	9. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах төсөл.....	35
	10. “КОВИД-19 цар тахлыг даван туулах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн үнэлгээ.....	38
	11. “Монгол дахь “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үнэлгээ.....	42
	12. “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, түүний 2016-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ”.....	44
	13. “Залуучуудын тогтвортой хөгжлийн корпус” хөтөлбөрийн суурь судалгаа.....	47
	14. Монгол Улс дахь алтны бичил уурхайн эрх зүйн орчин, хууль бус санхүүгийн урсгалын талаар судалгаа.....	50
	15. “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн эцсийн үнэлгээ.....	52
	16. “Цахим Марафон” төсөл.....	56
	17. Дэд бүтцийн бүтээн байгуулалтад талуудын ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх говийн загвар: Монгол туршлагыг Төв Азид.....	60
	18. Монгол ногоо төслийн суурь судалгаа 2020.....	63
	19. “Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь-3” төслийн эцсийн шатны хөндлөнгийн үнэлгээ.....	67
	20. Монгол – Австралийн Нийгэмлэг “Mozzies”-ийн засаглал, үйл ажиллагааны хөндлөнгийн үнэлгээ.....	69

9

Хэрэгжиж буй төслүүд 71

- 21. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл: “Хувийн Хэвшил болон Их, Дээд сургуулиудын Хамтын Ажиллагааг Бэхжүүлэх” туршилтын төсөл 71
- 22. “Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслийн эцсийн үнэлгээ..... 73
- 23. Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл 76
- 24. Улаан буудай тариаланчдын индексжүүлсэн даатгалын судалгаа..... 79
- 25. “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийн Амьжиргааг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн “Нийгэм-Эдийн засгийн шинжилгээ ба суурь судалгаа” 81
- 26. “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийн Байгаль орчны харилцааны бүрэлдэхүүн хэсгийн “Мэдлэг, хандлага, туршлагын судалгаа” 83
- 27. “Улаанбаатар хот руу чиглэсэн дотоод шилжих хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө ба үр дагавар” судалгаа 85
- 28. Олон нийтийн санал бодлын судалгаа..... 88
- 29. Ид шидийн орон-2 олон нийтийн төвийн ойролцоох хороод дахь олон нийтийн хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, туршлагыг тандах судалгаа 90

10

Бусад төслүүд 92

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа зөвлөх үйлчилгээ хүргэдэг Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болно.

ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

ТУРШЛАГА:

СУДАЛГАА - Бид мэргэжлийн, шинжлэх ухаанч арга зүйгээр олон салбар хамарсан судалгааны ажлын туршлагатай. Тоон ба чанарын аргыг ашиглан шинэлэг, салбар хоорондын судалгааны төслийн дизайныг боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Судалгааны мэдээллийн найдвартай байдалд чанарын хяналт тавьж, үр дүнг сүүлийн үеийн судалгааны мэдээлэл боловсруулах программ дээр гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийн үр дүнг боловсруулж байна.

122
ТӨСӨЛ

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ - Хяналт, үнэлгээний ажлууд манай байгууллагын гүйцэтгэж буй ажлын гуравны нэг орчим хувийг эзэлдэг. Бид Засгийн газар болон Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдэд хараат бус, хөндлөнгийн шинжилгээ хийж, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу баримт нотолгоонд суурилсан дүгнэлт гаргахыг эрмэлздэг.

84
ТӨСӨЛ

Манай байгууллага нь Монголын Үнэлгээний Сүлжээг санаачлагчдын нэг бөгөөд гишүүдийн хамтаар Үндэсний Үнэлгээний стандартыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ - Бид сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахдаа олон төрлийн аргачлал, арга зүйг ашиглахаас гадна өөрсдийн туршлагаараа байнга баяжуулж, шинэчилдэг. Сургалтууд нь төсвийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, байгууллагын чадавхыг бэхжүүлэх зэрэг олон сэдвийг хамардаг. Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа оролцооны, интерактив аргачлал ашигладаг ба зохион байгуулалт, оролцогчдын хэрэгцээний үнэлгээ, сургалтын материал, модулийн боловсруулалт, баримтжуулалт (зураг, тэмдэглэл гэх мэт) болон сургалт бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж цаашид сайжруулах боломж, үр дүнг үнэлдэг.

20
ТӨСӨЛ

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ - Манай байгууллагын хэрэгжүүлдэг төслүүд судалгаагаар хязгаарлагддаггүй. Бид бодлогын түвшний шийдвэр гаргагчдад нөлөөлөх төрөл бүрийн арга зүйн зөвлөх үйлчилгээ болон нөлөөллийн төслүүд төлөвлөн, хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хөгжлийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, арга зүй, санал зөвлөмж дэвшүүлэх;
- Байгууллагын дотоод гадаад орчны шинжилгээ хийх, чадавхжуулах стратеги боловсруулах зэрэг үйлчилгээнүүд үзүүлдэг.

28
ТӨСӨЛ



Онц бөгөөд бүрэн эрхт элчин
сайд, IRIM-ийн Ерөнхийлөгч
Х.Бэхбат



Гүйцэтгэх захирал
Л.Цэлмэгсайхан

Хэдийгээр 2020 он сорилтоор дүүрэн, амаргүй жил болон шувтарсан ч, манай байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй үргэлжилж, олон улсын болон төрийн байгууллагуудыг хараат бус, бодит судалгаа, мэдээллээр хангах замаар шийдвэр гаргалтыг илүү оновчтой, хүртээмжтэй болгоход хувь нэмрээ оруулж ажиллалаа. Ялангуяа, хөгжлийн түнш байгууллага, төрийн байгууллагын захиалгаар КОВИД-19 цар тахлын нөлөө өрхийн амьжиргаа, зорилтот бүлгийн ажил байдал, бичил болон жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж буй талаар олон тооны судалгааг гүйцэтгэлээ.

Энэхүү ээдрээт цаг үед, эерэг өөрчлөлт гарахад бага ч атугай хувь нэмэр оруулахын тулд бид юу хийж чадах вэ гэдэгт анхаарлаа хандууллаа. Өөрсдийн санаачилсан урт хугацааны судалгааны төслүүдээ тасалдалгүй санхүүжүүлэн, ээлжит тайлангуудаа гаргалаа. Тухайлбал, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хэмжих “Цахим ил тод байдлын индекс” судалгааны ес дэх тайланг гаргаж олон нийтэд танилцууллаа. Улмаар, улсын хөгжлийг үнэлдэг эдийн засгийн уламжлалт хэмжүүрээс гадна нийгмийн байдлыг илтгэсэн хэмжүүр, үзүүлэлтийг ашиглах оролдлого болох “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны будаг нь хангалсан хоёр дахь тайлан бэлэн болоод байна. Энэ удаагийн тайлан ахмад настнуудын сайн сайхан байдал сэдвээр нарийвчлан гарч байна.

Байгууллагынхаа нийгмийн хариуцлагын хүрээнд, олон улсын “Give2Asia” байгууллагатай хамтран КОВИД-19 цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн, зорилтот бүлгийн, орлого багатай өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх хүмүүнлэгийн төсөл хэрэгжүүлж, Хүүхэд хамгаалал, хүний наймааны асуудлаар сүүлийн 8 жил идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Лантуун дохио ТББ-ын “Ид шидийн орон-2” хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох, бодлого, стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлээ.

Түүнчлэн дотоод үйл ажиллагааны хувьд, хөл хорионы нөхцөл байдалд технологийн дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран үр дүнтэй хамтран ажиллаж, ажил амьдралын тэнцвэртээ ахиц гаргасан, суралцсан жил боллоо.

Уламжлал ёсоор бид жилийн тайлангаа бэлтгэн Монголын хөгжлийн асуудлуудыг сонирхогч хэн бүхэнд IRIM-ийн 2020 онд хэрэгжүүлсэн төслүүд, тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээлэл болгон хүргэж байна.

Бидний үнэт зүйлс, мэргэжлийн ур чадварт итгэл хүлээлгэсэн харилцагч байгууллагууд, хамтран ажилласан судлаачид, зөвлөхүүд, бидний судалгаанд оролцож үнэтэй санал бодлоо нэмэрлэсэн Монголын өнцөг булан бүрд амьдран суугаа иргэд, олон нийтдээ 2021 онд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье.

БИДНИЙ ТУХАЙ



IRIM судалгааны хүрээлэн нь 2008 онд дөрвөн хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааныхаа гарааг эхэлж байсан бол өнөөгийн байдлаар нийт 24 үндсэн ажилтантай, 300 гаруй үндэсний болон олон улсын гэрээт зөвлөх, судлаачдын багтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Бид төслийн удирдлага, сургалт, судалгаа, үнэлгээний чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмрээ оруулахыг зорьж ажилладаг.

Энэ хугацаанд бид өөрийн орны онцлогийг тусгасан, үр дүнг чухалчилсан, үйлчлүүлэгч төвтэй төслийн менежментийн шийдлүүдийг санал болгохоос гадна нотолгоонд суурилсан **чанартай** мэдээлэл бий болгох, **хараат бус**, хөндлөнгийн байр суурийг хадгалах, нийгэмд үзүүлэх **үр нөлөөгөө** дээшлүүлэх зарчмыг үргэлж баримталсаар ирсэн.

Манай байгууллагын гүйцэтгэдэг зөвлөх үйлчилгээ, судалгааны ажил нь өргөн хүрээний нийгмийн асуудлуудыг хамардаг, түүн дотроо засаглал, боловсрол, хөдөлмөрийн зах зээл болон уул уурхай, байгаль орчны салбарт илүүтэй төвлөрдөг.

Улмаар бидний үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж 2013 онд MIRIM (Marketing and Innovation Research Institute of Mongolia) Консалтант компанийг үүсгэн байгуулж маркетинг, инновацын судалгааны чиглэлээр мөн үйл ажиллагаа явуулж байна.

IRIM ТООГООР

НИЙТ
241
ТӨСӨЛ



2008 ОНЫ
4 сар

2021 ОНЫ
4 сар

103
Засаглал

36
Боловсрол

30
Уул уурхай,
байгаль орчин

14
Хөдөлмөрийн
зах зээл


58
Бусад




181,268
Респондент



99 Захиалагч
155 Хамтрагч



ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУД



Архангай	36	Дорноговь	39	Сэлэнгэ	41
Баян-Өлгий	31	Дундговь	33	Төв	34
Баянхонгор	42	Завхан	35	Ховд	58
Булган	23	Орхон	32	Хөвсгөл	43
Говь-Алтай	39	Өмнөговь	48	Хэнтий	37
Говьсүмбэр	25	Өвөрхангай	41	Улаанбаатар	162
Дархан-Уул	43	Увс	39	БХНАУ-ын Эрээн хот 1	
Дорнод	38	Сүхбаатар	32	Нийт	952

Мэргэжлийн гишүүнчлэл болон ёс зүйн зарчим



Ази номхон далайн улс орнуудын "Нийгмийн хариуцлагын төлөв сүлжээ" байгууллагын гишүүнээр 2010 оноос хойш ажиллаж байна.



Олон Улсын Социологийн Холбоонд (ISA) 2011 оноос хойш Монгол Улсаас албан ёсны гишүүн бөгөөд тус байгууллагаас батлан гаргасан "Ёс зүйн дүрэм"-ийг чанд сахин ажилладаг.



2016 оны 8 сард "Ази-Номхон далайн Үнэлгээний Холбоо"-нд албан ёсоор нэгдэн орсон Монголын анхны байгууллага юм. Мөн 2017 оноос тус холбооны ТҮЗ-ын гишүүн байгууллагаар сонгогдон ажиллаж байна.



IRIM нь Монголын үнэлгээний сүлжээг байгуулах санаачилгыг эхлүүлсэн бөгөөд энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус, ОУ-ын байгууллагын мэргэжилтэн, зөвлөхүүдийг эгнээнд нэгтгэсэн. Одоогоор сүлжээний гишүүдэйгээ хамтран Үндэсний үнэлгээний стандартыг Монголд нэвтрүүлэхээр ажиллаж байна.



IRIM нь 2016 оноос "Сайн сайхан байдалын судалгаа"-г санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сард "Азийн Субъектив сайн сайхан байдалын олон улсын консорциум"-д Монгол Улсыг төлөөлөн гишүүнээр нэгдэн орсон.



Монгол Улсын Жендрийн Үндэсний Хорооны орон тооны гишүүнээр 2017 оноос ажиллаж байна. Энэ хүрээнд нийгмийн бүхий л салбарт, жендрийн тэгш эрхийг хангуулах, төрийн бодлогод жендрийн тэгш эрхийн зарчмыг хангуулах тал дээр иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөн ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээнд 2018 оноос Innovation for Change Team Азийн бус нутгийн сүлжээнд нэгдэн орсон бөгөөд мөн тус онд ТҮЗ-ийн гишүүн байгууллагаар сонгогдон. Одоогоор иргэний нийгмийн байгууллагуудын эрхийг хамгаалах, түүнд тулгарч буй баршээнийг даван туулах арга замыг бий болгох зорилго дор сүлжээний гишүүдтэй хамтран ажиллаж байна.



2019 онд IRIM Судалгааны хүрээнд Give2Asia олон улсын хандивын сүлжээнд гишүүнээр элссэн. Тус сүлжээ нь Азийн хөгжиж буй улс орнуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой орон нутгийн иргэдийн төсөл, хөтөлбөрийг дэмжих хөрөнгө босгох чиглэлээр үйл ажиллагаагаа Азийн 23 оронд явуулдаг АНУ-д төвтэй ашгийн бус байгууллага юм. Уг сүлжээнд нэгдсэнээр бид Монгол улс даяа хөгжиж баршээтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, оролцдог нэмэгдүүлэх чиглэлийн төслүүдийг санаачлан, хэрэгжүүлж байна.



IRIM судалгааны хүрээнд Азийн ардчиллын судалгааны сүлжээнд 2020 онд гишүүнээр элсэв. Уг сүлжээ нь 2013 онд байгуулагдсан, Ази тивд ардчилсан засаглал, хүний эрхийг дэмжих чиглэлд судалгаа, шинжилгээ хийдэг байгууллага юм. Өдгөө 14 орны голлох 21 тинк танхунд гишүүнчлэж, Азийн Барометрийн судалгаагаараа олон улсад танигдан байдаг.

Хамтрагч байгууллагууд



2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧОО

ТУЗ-ийн гишүүн А.Долгион ОУ-ын Reagen-Fascell Democracy Fellowship хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 1 сарын 31-нд зохион байгуулагдсан хуралд “Thirty Years After Mongolia’s Democratic Revolution: Has Democracy Delivered for All?” сэдвээр илтгэл тавилаа.



КОВИД-19 цар тахал дэлхий нийтээр тархан, дотоодод анхны тохиолдол илэрснээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн. IRIM судалгааны хүрээлэнгийн ажилчид 2 сараас ажлаа цахимаар бүрэн явуулах бэлтгэл ажлаа ханган 3 сараас эхлэн зайнаас ажиллах горимд бүрэн болон хагас байдлаар шилжин ажиллаж байна.



Оюутнуудын дадлага болон сайн дурын хөтөлбөрийг бид жил бүр зохион байгуулдаг. 2020 онд МУИС-ийн Социологийн төгсөх ангийн 5 оюутан практик дадлага хийсэн бол мөн Зориг сан ТББ, Монголын Оюуны Санаачилга ТББ-н хамтарсан “Залуу дадлагажигч” хөтөлбөрийн оролцогч 12-р ангийн 2 сурагч манай байгууллагад дадлагажлаа.



1



IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх Ц.Батсугар 2020 оны 2 сарын 1-ны өдөр Японы Токио хотноо зохион байгуулагдсан Азийн сайн сайхан байдлын консорциумын хуралд оролцож, 2019 оны 09 сард МУ-д хийгдсэн Сайн сайхан байдлын чанарын судалгааны үйл явц, мэдээлэл цуглуулалт, урьдчилсан үр дүнг танилцууллаа.

2



3

Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан Бизнэс өрөг нэвтрүүлэгт оролцож КОВИД-19 цар тахлын дараа бизнесүүд яаж өөрчлөгдөх вэ? сэдвээр саналаа хуваалцлаа.

4



5

“Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ-аас Азийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Залууст чиглэсэн бодлого, шийдлийн хакатон-2020” онлайн хакатонд Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан ментороор, Инновац, технологийн менежер Т.Азбилэг, Ахлах судлаач Т.Элбэрэл нар оролцож, дээд боловсролын цахим хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шийдэл боловсрууллаа.

6

НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар “Онцгой байдлын үеийн зайны сургалтын (Теле хичээл) үр дүн, тохиромжтой байдлын үнэлгээ”-г нийслэл болон 5 аймгийн хэмжээнд амжилттай гүйцэтгэв. Цар тахлын улмаас авч хэрэгжүүлсэн хөл хорио нь боловсролын салбарт шинэ сорилтыг бий болгосон. Үүнтэй холбоотойгоор хууль эрхзүй, санхүүгийн орчныг судлан, үр дүнтэй байдлыг үнэлж, цаашид сайжруулах санал зөвлөмж боловсруулан, теле хичээлийн үеийн хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн нөхцөл байдлыг үнэлсэн.



2020 оны томоохон мэдээлэл цуглуулалттай судалгааны нэгийг бид Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн (БНОУХ) захиалгаар амжилттай хэрэгжүүллээ. Судалгаа нь Монгол дахь ардчилсан институтийн нөхцөл байдал, тэдгээрийн үйл ажиллагаа болон засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлагатай байдал, иргэдэд хүрч буй хамрах хүрээний талаарх залуусын санаа бодлыг судлан, тэдний мэдээлэл авах эх үүсвэрийг тодорхойлоход чиглэсэн. Судалгааны үр дүнг БНОУХ-ийн цахим хуудаст хандан үзэх боломжтой.



IRIM судалгааны хүрээлэн АНУ-д төвтэй Give2Asia олон улсын байгууллагаас КОВИД-19 цар тахлаас үүдэн хүнс, тэжээлийн дутагдалд орсон эмзэг бүлгийн өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх төсөл хэрэгжүүлэх 10,000 ам. долларын тэтгэлэг авлаа. Тэтгэлгээр 2 дүүрэг, 3 аймгийн гэр хороололд амьдарч буй 220 хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй эмзэг өрхүүдэд хүнс, тэжээлийн тусламж үзүүллээ.



7



8

Зуны сургалт нь IRIM-ийн жил бүр уламжлал болгон дотооддоо зохион байгуулдаг гол арга хэмжээний нэг юм. 2020 онд Харвардын ИС-ийн Кеннеди сургуулийг төгсөгч, IRIM-ийн зөвлөх Л.Булган “Social Innovation Skills: Human Centered Design & Design Thinking” сэдвээр бүтэн өдрийн сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар бид Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгааныхаа үр нөлөөг дахин хэлэлцэж, тодорхой санал шийдлүүдийг гаргасан.

9



Лантуун дохио ТББ-аас хэрэгжүүлж буй Ид шидийн орон-2 төслийн зорилтот бүлгийн хүүхдүүдийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох, цаашдын стратеги, төлөвлөгөөг боловсруулахад манай байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлэн санамж бичиг байгууллаа.

10

11



IRIM нь ‘Innovation for Change Central Asia’ (I4C CA)-тай хамтран ‘Цахим Марафон’ төслийг санаачлан амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд Төв Азийн 5 улсын 6 баг ил тод байдал, хариуцлага, авлигын эсрэг санаачилга бүхий төслийг санаачлан боловсруулж өөрсдийн улсдаа хэрэгжүүлсэн. Манай байгууллага эдгээр төслүүдийг сонгон шалгаруулж, хэрэгжилтийн явцад зөвлөгөө өгч, төслийн үе шатуудад дэмжлэг үзүүлэн ажиллав.

12

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДАЛ” 2020 ЭЭЛЖИТ ТАЙЛАН ГАРЛАА



IRIM судалгааны хүрээлэн “Төрийн байгууллагын цахим ил тод байдал”-н мониторинг судалгааг 9 дэх жилдээ нийгмийн хариуцлагын хүрээнд бие даан амжилттай гүйцэтгэж байна. Энэхүү судалгааны зорилго нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” болон “Шилэн дансны тухай хууль”-д заасан төрийн байгууллагуудын вэбсайтад байршуулах ёстой мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байгаа эсхийг шинжлэн үнэлэх, цаашид төрийн байгууллагын ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны үр дүнгээс харахад Улсын хэмжээнд төрийн байгууллагуудын цахим ил тод байдал 0.537 буюу “СУЛ” түвшинд үнэлэгдлээ. Тухайлбал, хуульд заасан мэдээллээ хангалттай түвшинд оруулаагүй байгууллага нийт байгууллагын 85 хувийг эзэлж байхад дөнгөж 15 хувь нь л хуулийн дагуу мэдээллээ хангалттай, сайн оруулж байна.

Тус судалгааны тухай нийтэлсэн IRIM судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач Х.Баярмаагийн ярилцлагыг дараах линкээр орж танилцана уу. Х.БАЯРМАА: Төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сул гэж үнэлэгдсэн – [Өнөөдөр сонины ярилцлага \(unuudur.mn\)](http://unuudur.mn)

“МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА” 2020 ЭЭЛЖИТ ТАЙЛАН ГАРЛАА



2017 оноос хойш эрхлэн гаргаж байгаа манай брэнд судалгааны нэг нь Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа билээ. Энэ жилийн судалгааны онцлог нь 2019 онд хэрэгжүүлж эхэлсэн Монгол, Тайланд, Индонез, Филиппин, Вьетнам, Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг Азийн найман орны аз жаргалыг дэмжихэд чиглэсэн нийгмийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглах, олон улсад харьцуулагдах боломжтой мэдээлэл цуглуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлээ.

Судалгаагаар амьдралын түүх судлах чанарын судалгааны аргыг голчлон ашигласан бөгөөд мэдээлэл цуглуулалтад хөдөө орон нутгийн 49-69 насны нийт 363 иргэдийг урьдчилсан тандалт судалгаанд хамруулж, түүх судлах чанарын судалгаанд хамрагдах 12 оролцогчийг сонгов. Энэхүү судалгааны үр дүн бүхий бие даасан тайлан нь 2021 оны 5 сард хэвлэгдэн олон нийтэд тархаагдах юм.

ЛАНТУУН ДОХИО ТББ-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Хүүхэд хамгаалал, хүний наймааны чиглэлээр сүүлийн 8 жил идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Лантуун дохио ТББ-н анхны томоохон төсөл болох Ид шидийн орон-1 төвд бид IRIM судалгааны хүрээлэн байгуулагдсаны 10 жилийн ойн тэмцээний шагналын сангаар хандив өргөж байсан билээ. Харин 2020 оны 7 сараас хоёр байгууллага хамтран ажиллах саналууд солилцож, үүний үр дүнд 10 сарын 03-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг санамж бичгээр IRIM судалгааны хүрээлэн

Лантуун дохио ТББ-н Ид шидийн орон-2 хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлон, цаашид баримтлах бодлого, стратеги боловсруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлсэн юм.

Энэ хүрээнд бид 2020 онд тус төвийн үйл ажиллагааны “Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ”-г боловсруулаад байна. Уг хүрээнд үндэслэн бидний дараагийн алхам “Ид шидийн орон-2” олон нийтийн төвийн ойролцоох хороод дахь олон нийтийн хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, туршлагыг тандах судалгаа”-ны ажил юм. КОВИД-19 цар тахал дотоодод тархсантай холбоотойгоор тус судалгааны талбар дахь мэдээлэл цуглуулалт хойшилж, хүлээлгийн төлөвт байгаа бөгөөд халдварын нөхцөл байдал тогтворжих үед мэдээлэл цуглуулах ажлыг Ид шидийн орон-2 олон нийтийн төвийн ойролцоох 3 хороодод хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.



GIVE2ASIA – ХҮНСНИЙ ТУСЛАМЖИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖЛЭЭ

IRIM судалгааны хүрээлэн Give2Asia олон улсын байгууллагаас КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй хөл хорионы дэглэмийн нөлөөнд хамгийн их өртөж байгаа нийгмийн эмзэг



бүлгийн иргэд болох орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, эмэгтэй өрх толгойлогчтой өрхүүдэд чиглэсэн хүнс, тэжээлийн тусламжийн төслийг нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд 2 дүүрэг, 3 аймгийн гэр хороолол дахь дээр дурдсан бүлгийн 220 өрхөд хүнсний тусламж хүргэн, энэ хүнд хэцүү нөхцөлд бага ч болов сэтгэлийн болон хүнсний тусламж үзүүлсэндээ бид баяртай байна.

INNOVATION FOR CHANGE – ЦАХИМ МАРАФОН ТӨСӨЛ ХЭРЭГЖЛЭЭ



IRIM судалгааны хүрээлэн Innovation for Change олон улсын сүлжээний Төв Ази дахь салбарын гишүүн байгууллага билээ. Уг сүлжээгээр дамжуулан бид “Цахим Марафон” төслийг ил тод байдал, хариуцлага, авлигын эсрэг санаачилгуудыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах шинэлэг, шийдлүүдийг дэмжин ажиллаа. Төслийн хүрээнд бид Төв Азийн 7 орноос санаачилгуудыг хүлээн авч, 5 орны иргэний нийгмийн байгууллага, нийгмийн идэвхтнүүдээс бүрдсэн 6 багийг шалгаруулж

өөрийн улс орондоо ил тод байдал, авлигын эсрэг шинэлэг шийдлүүдийг гаргасан төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүллээ. IRIM эдгээр багуудыг төслөө хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, менторуудтай холбох, сургалт семинар зохион байгуулах үйл ажиллагааг хариуцан ажилласан.

IRIM-ИЙН ЗӨВЛӨХ Ц.БАТСУГАР АЗИ-НОМХОН ДАЛАЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ТУЗ-ИЙН ГИШҮҮНЭЭР СОНГОГДОН АЖИЛЛАЖ БАЙНА



Ц.Батсугар нь засаглал, иргэдийн оролцоо, иргэний нийгэм, хөгжлийн бодлогын судлаач юм. IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирлын албан тушаал хашиж байсан тэрээр Монгол Улсын Жендэрийн Үндэсний Хорооны гишүүн асан, Монголын Үнэлгээний Сүлжээний үүсгэн байгуулагчдын нэг билээ.

Asia-Pacific Evaluation Association нь бүс нутаг дахь үр дүнд суурилсан үнэлгээ, ил тод, нээлттэй байдлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлд анхааран ажилладаг байгууллага юм. Манай байгууллага нь тус байгууллагад 2016 оноос хойш гишүүнээр элссэн бөгөөд Ц.Батсугар 2020 оны 1 сараас эхлэн ТУЗ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Ингэснээр бид Ази номхон далайн үнэлгээний

сүлжээнд өөрсдийн дуу хоолойг улам хүчтэй хүргэж, олон арга туршлагыг өөрсдийн орондоо хэрэгжүүлэх боломж нэмэгдэж байгаа юм.

IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН АЗИЙН АРДЧИЛЛЫН СУДАЛГААНЫ СҮЛЖЭЭНД ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ



Азийн ардчиллын судалгааны сүлжээ нь 2013 онд байгуулагдсан, Ази тивд ардчилсан засаглал, хүний эрхийг дэмжих чиглэлд судалгаа, шинжилгээ хийдэг байгууллага юм. Тус сүлжээ нь өдгөө 14 орны голлох 21 тинк танкууд гишүүнчлэлтэй, Азийн Барометрийн судалгаагаараа олон улсад танигдсан байдаг. Манай байгууллага 2020 оны 10 сард албан ёсоор уг сүлжээний гишүүнээр нэгдэн орлоо.

IRIM судалгааны хүрээлэн ардчиллын чиглэлээр сүүлийн жилүүдэд судалгаа, нөлөөллийн ажлуудыг идэвхтэй хийж ирсэн. Тэдгээрийн

дотроос ардчилал судлал, ардчилсан институтиудийг сайжруулах чиглэлээр 2018 онд “21-р зууны Ардчилал: Сорилтууд болон Цаашдын Хандлага” сэдэвт олон улсын хурлыг амжилттай зохион байгуулсан билээ.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ 2020



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- IRIM судалгааны хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Цахим ил тод байдлыг хэмжих зорилго нь төрийн байгууллагуудын цахим мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг үнэлж, тоон үзүүлэлтээр хэмжин, цаашид сайжруулахад хувь нэмэр оруулах явдал юм.

Цахим ил тод байдлын индексээр цахим хэрэгслээр нээлттэй болгож буй мэдээллийн хэмжээ, цар хүрээг үнэлнэ. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” болон “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” засгийн газрын тогтоол, бусад холбогдох дүрэм журамтай хэр нийцэж байгаад төвлөрнө.




2020

12-р сар

2021

1-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төрийн захиргааны түвшний нийт 86 байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг тооцон гаргасан. Үүнд:

- Монгол Улсын Яам -13
- Монгол Улсын Хэрэгжүүлэгч Агентлаг -22
- Монгол Улсын Тохируулагч Агентлаг -12
- Монгол Улсын Орон Нутгийн Захиргаа - 21
- Нийслэл, Дүүргийн захиргаа - 9
- Улсын Их Хурал болон түүний харьяа байгууллага -9

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Төрийн тухай үзэл баримтлал нь орчин үед иргэдийн ашиг сонирхлыг “төв” болгон төрийн үйл ажиллагааг тэдэнд ойртуулах, төрөөс иргэдтэй харилцах харилцааг сайжруулахад чиглэгдэж, энэ нь технологийн дэвшилттэй хослон хөгжиж байна. Цахим технологид тулгуурласнаар Засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, мэдээллийн чөлөөт урсгал нэмэгдэх боломж бүрддэг бол нөгөө талаар иргэд аливаа мэдээлэл, үйлчилгээ нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломж бүрддэгээрээ давуу талтай.

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор баталсан Төрийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” (2009) болон “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” (2011) хуулийн дагуу одоогоор төрийн захиргааны

бүх байгууллагууд мэдээллийн ил тод байдлын талаар тайлан мэдээллээ гарган нийтэлж байгаа ч энэ нь тодорхой стандартаар хэмжигдэх, харьцуулагдах боломж муу байна.

Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь 2010 оноос хойш дээрх хууль дүрмийн хэрэгжилтийг үнэлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилготойгоор төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг үнэлж ирсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Цахим ил тод байдал нь нэгдмэл нэг оноогоор илэрхийдэгдэх бөгөөд 0-ээс 1-ийн хооронд утга авна. Ил тод байдлын утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

Цахим ил тод байдал нь 3 дэд бүлэг, 8 индикатораас бүрдэх ба нийт 45 асуулттай. Үүнийг задалбал Технологийн бүлэг 6, Нээлттэй мэдээллийн агуулга 36, Иргэдийн оролцоо ба харилцаа 4 асуулттай байна.

Технологи – Тухайн цахим хуудаст хандалт хийхэд хялбар нэвтэрч байгаа эсэх болон хайлтын систем, хэлний сонголт гэх мэт үзүүлэлтээр хэмжсэн.

Нээлттэй мэдээллийн агуулга – Тухайн байгууллагын бүтэц, холбоо барих мэдээллүүд болон хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх холбогдох хуульд заасан мэдээллүүд байгаа эсэх. Мөн статистик болон бусад нээлттэй өгөгдлүүдийг ашиглах боломжтой эсэхийг багтаасан.

Иргэдийн оролцоо ба харилцаа – Хандалт болон ямар нэг байдлаар харилцах боломжтой байгаа эсэхийг хэмжих зорилготой шалгуурууд багтсан.

Бүрэлдэхүүн хэсэг, дэд бүлэг, индикаторуудын задаргаа болон жингийн тооцооллыг доорх хүснэгтээс харах боломжтой.



Зураг 1. Цахим ил тод байдлын индексийн бүтэц, жин

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн захиргааны 86 төрийн байгууллагын индексийн үр дүнг нэгтгэн тооцоо. Цахим ил тод байдлын ерөнхий индекс улсын хэмжээнд 0.537 гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд үнэлэгдлээ. Үүнийг өнгөрсөн

онтой харьцуулахад (0.518) бага хэмжээгээр өссөн мэт боловч тийм ч мэдэгдэхүйц өөрчлөлт гарсангүй.



Зураг 2. Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшин

Үнэлгээнд хамрагдсан 86 байгууллагаас 15 хувь нь буюу 13 байгууллага л ил тод 'хангалттай' түвшинд байгаагаас ердөө 2 байгууллага нь "сайн" түвшинд байна. Нийт байгууллагын тал хувь нь болох 42 байгууллага сул түвшинд үнэлэгджээ. Үлдсэн байгууллагуудын 24 нь "хангалтгүй" түвшинд, 7 байгууллага нь "муу" түвшинд үнэлэгдсэн байна.

Тиймээс цаашид цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Үүнийг индикатор тус бүрээр өнгөрсөн онтой харьцуулахад ямар өөрчлөлттэй байгааг дараах хүснэгтээс харна уу.

Индикатор тус бүрээр нь авч үзвэл 8 индикатораас 4 индикатор нь өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан, 1 индикатор хэвэндээ, 3 индикатор өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс зөвхөн 2 индикатор (технологийн нийцтэй байдал ба төсөв санхүү) "хангалттай" түвшинд үнэлэгдсэн бол үлдсэн индикаторууд "сул" ба "хангалтгүй" түвшинд үнэлэгджээ. Харин технологийн үр нөлөөтэй байдал хамгийн хангалтгүй байна.

Хүснэгт 1. Цахим ил тод байдлын нэгдсэн индекс

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН НЭГДСЭН ҮР ДҮН				
№	Үзүүлэлтүүд	2019	2020	Өөрчлөлт
Технологи		0.598	0.529	0.449
1	Технологийн нийцтэй байдал	0.749	0.684	-0.065
2	Технологийн үр нөлөөтэй байдал	0.447	0.374	-0.073
Нээлттэй мэдээллийн агуулга		0.403	0.534	0.131
3	Үйл ажиллагаа	0.715	0.599	-0.116
4	Хүний нөөцийн бодлого	0.439	0.438	-0.001
5	Төсөв, санхүү	0.507	0.653	0.146
6	Худалдан авах ажиллагаа	0.320	0.426	0.106
7	Нээлттэй өгөгдөл	0.639	0.608	-0.031
Иргэдийн оролцоо ба харилцаа		0.523	0.591	0.068
8	Харилцаа ба эргэх холбоо	0.523	0.591	0.068
Цахим ил тод байдлын үр дүн		0.518	0.537	0.019

ДУГНЭЛТ

Цахим хуудасны ил тод байдал “сул” (0.537) түвшинд байна. Үүнийг өмнөх жилүүдийн дунджаар аваад үзвэл сүүлийн 5 жил мэдэгдэхүйц өөрчлөлтгүй дунджаар 50 хувьтай байгаа нь цаашид цахим хуудасны ил тод байдлыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Цахим хуудаснуудын **технологийн нийцтэй байдал нь ерөнхийдөө “хангалттай”**, бүхэлдээ ямар ч хөтчөөс (internet explorer, firefox, chrome) хайсан шууд илрэх, мөн Монгол Улсын Засгийн газрын цахим хуудсанд (www.zasag.mn) хуудасны холбоосоор шууд холбогдох боломжтой зэрэг нь хэрэглэгчид олоход амар, хялбар байдлыг бий болгож байна. Гэвч **технологийн үр нөлөөтэй байдал “хангалтгүй”** түвшинд байна. Учир нь зарим байгууллагуудын цахим хуудасны бүтэц байхгүй, дотоод хайлтын систем байхгүй, гадаад хэл дээрх мэдээлэл ордоггүй зэрэг нь тухайн цахим хуудаснаас хэрэгцээт мэдээллийг хялбар олж авахад бэрхшээл учруулж байгаа юм.

Агуулгын хувьд ерөнхийдөө “сул” түвшинд байна. **Үйл ажиллагааны талаарх мэдээллийг** байршуулах байдал өнгөрсөн оноос **буурсан**. Энэ нь 2020 онд Засгийн газар шинээр бүрэлдсэнтэй холбоотой, бүтэц зохион байгуулалт, холбогдох албан тушаалтнуудын

талаарх мэдээллүүд тавигдаагүй байгаа үзэгдэл нийтлэг байв. **Харин төсөв, санхүүгийн чиглэлээр** тавьж буй мэдээлэл нэмэгдэж **“хангалттай”** түвшинд хүрсэн байгаа нь энэ үзүүлэлтийн гүйцэтгэлийн хянах тогтолцоо бусад үзүүлэлттэй харьцуулахад сайн байдагтай холбоотой гэж үзэж байна. Бусад ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүд “хангалтгүй” түвшинд байсаар байна.

Иргэдтэй харилцах боломжийн үзүүлэлт (0.591) өнгөрсөн оноос (0.523) бага зэрэг **нэмэгдсэн ч “хангалтгүй” хэвээр** байна. Иргэд санал, хүсэлт, гомдлоо цахимаар гаргах боломж болон чат гэх мэт онлайн шууд холбогдох боломж бага байна. Хэдийгээр 2020 он цар тахлын нөлөөгөөр онлайн горимд шилжин ажиллах шаардлага салбар бүрд тулгарч байгаа ч төрийн байгууллагын хувьд цахим хуудсаараа дамжуулан энэ төрлийн шинэчлэлт, хөгжүүлэлтийг хийх байдал сул байгааг харууллаа.

Байгууллагын төрлөөр нь дүгнэвэл **Аймгуудын ЗДТГ-ын** үзүүлэлт бусдаасаа хамгийн **өндөр** үнэлгээтэй гардаг нь хамгийн тогтвортой нэгж байдагтай холбоотой. Гэвч аймгуудын дундаж үнэлгээ нь (0.576) **сул** түвшинд байгаа нь цаашид илүү сайжрах шаардлага бий гэдгийг харууллаа. Харин **тохируулагч агентлагийн** дундаж үнэлгээ (0.444) сүүлийн хоёр жилд **“хангалтгүй”** гэсэн түвшинд байна.




2020

6-р сар

2021

5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Дундговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймаг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Манай байгууллага нь “Олон Улсын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум” (ОУНССБСК)-д анх 2016 онд гишүүнээр элссэн бөгөөд жилд 1-2 удаа энэ чиглэлийн ОУ-ын хэмжээний томоохон хурал цуглаанд өгүүлэл, илтгэл хэлэлцүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээний ажил зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна. Энэ жилийн хувьд найман гишүүн орны судлаачид хамтран хэрэгжүүлж буй Азийн орнуудад хувь хүний аз жаргалыг дэмжихэд чиглэсэн нийгмийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглах, олон улсад харьцуулагдах боломжтой мэдээлэл цуглуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

2020 онд төслийн хүрээнд хөдөө орон нутгаас нийт 12 оролцогчийг судалгаанд хамруулсан бөгөөд амьдралын түүх судлах чанарын судалгааны аргыг голчлон ашиглав.

IRIM судалгааны хүрээлэнгийн санаачлан хэрэгжүүлдэг “Монголын Нийгмийн Сайн

Сайхан Байдлын Судалгаа” болон 2017-2020 онуудад хэрэгжүүлсэн төслүүдийн мэдээлэл цуглуулалтад хамрагдсан 49-69 насны нийт 363 иргэдийг урьдчилсан тандалт судалгаанд хамруулж хөдөө орон нутгаас судалгаанд хамрагдах 12 оролцогчийг сонгов. Ингэхдээ хүйс, аз жаргалын түвшин, гэрлэлтийн байдал, хүүхдийн тоо зэргийг суурь шалгуур болгосон. Урьдчилсан тандалт судалгааг цар тахлын нөхцөл байдалд нийцүүлэн утсаар зохион байгуулсан.

Хөдөө орон нутагт оршин суудаг иргэдийг хамруулсан чанарын мэдээлэл цуглуулалт КОВИД-19 цар тахалтай холбоотой хязгаарлалтуудын улмаас хойшлогдсон бөгөөд мэдээлэл цуглуулалтыг 2020 оны 10 сард IRIM судалгааны хүрээлэн бие даан гүйцэтгэв.

ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төсөл нь жилийн тайлан гарах явцад хэрэгжиж байсан ба 2021 оны 5 сард цуглуулсан мэдээллүүдийн үр дүн, дүгнэлт бүхий бие даасан тайлан хэвлэгдэн олон нийтэд тархаагдах тул энэ хэсэгт одоогоор ямар нэгэн мэдээлэл оруулах боломжгүй байна.

КОВИД-19 ЦАР ТАХЛААС ҮҮДЭН ХҮНС, ТЭЖЭЭЛИЙН ДУТАГДАЛД ОРСОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ӨРХҮҮДЭД ХҮНСНИЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ



ТЭТГЭЛЭГ ОЛГОСОН:

- Give2Asia

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

КОВИД-19 цар тахлаас үүдэн эдийн засгийн хүндрэлд орсон зорилтот бүлгийн өрхүүдэд хүнс тэжээлийн тусламж үзүүлэх зорилготой.




2020

8-р сар

2020

10-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Налайх, Сонгинохайрхан, дүүрэг болон Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, аймгийн 220 хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй зорилтот өрх

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

КОВИД-19 цар тахал дэлхий даяар тархсантай холбоотойгоор 2020 оны 2 дугаар сараас Монгол Улсын Засгийн Газар, Улсын Онцгой Комиссын шийдвэрээр бүх нийтийн болон хэсэгчилсэн хөл хорио тогтоосон. Нэг жил гаруй хугацааг дамнан үргэлжилсэн урт болон богино хугацааны хөл хорио, хязгаарлалууд нь нийгэм, эдийн засгийн олон сөрөг үр дагавруудыг бий болгож, энэ нь иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлж буйг сүүлийн үеийн тоо баримтууд бэлхнээ харуулж байна. Үүний үр нөлөө нийгмийн зорилтот бүлгийн өрхүүдэд, тэр дундаа орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон өрхүүдэд илүү хүчтэй тусаж байгаа тул цар тахлын хүнд хэцүү үеийг даван туулахад нийгэмдээ хувь нэмрээ оруулах зорилгоор IRIM судалгааны хүрээлэн зорилтот бүлгийн өрхүүдэд хүнс тэжээлийн тусламж үзүүлэх төслийг санаачлан, Give2Asia хандивын сүлжээний тэтгэлгийн тусламжтайгаар уг төслийг амжилттай хэрэгжүүлээд байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Төслийн хүрээнд (i) Сонгосон орон нутгууд дахь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүдийн нөхцөл байдалд түргэвчилсэн хэрэгцээ тодорхойлох судалгаа хийж, (ii) үнэлгээгээр хамгийн хэрэгцээтэй гэж тодорхойлогдсон бүтээгдэхүүнийг агуулсан хүнсний тусламжийн багц бэлтгэн, зорилтот өрхүүдэд тарааж (iii) олон нийтийг уг хүнд хэцүү нөхцөлд бие биедээ тусалж дэмжихийг уриалсан, дэмжлэг туслалцааны хэрэгцээг харуулсан видео бичлэг хийж өөрсдийн нийгмийн сүлжээний цахим хуудсаар дамжуулан олон нийтэд танилцуулаад байна.

Хүнсний тусламж үзүүлэх өрхүүдийг сонгосон аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран тодорхойлсон ба өрхүүдийг сонгохдоо өрхөд хөгжлийн бэрхшээлтэй гишүүн бий эсэхийг нэн тэргүүнд харгалзан үзсэн.

ТӨСЛИЙН ҮР ДҮН:

КОВИД-19 цар тахалтай нүүр тулсан хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхүүдийн нөхцөл байдалд түргэвчилсэн хэрэгцээний үнэлгээ хийхэд эдгээр өрхүүдэд хамгийн хэрэгцээтэй байгаа зүйлсэд гурил, будаа, мах зэрэг хүнсний хэрэглээний өдөр тутмын бүтээгдэхүүнүүд дурдагдаж байв.



Үүнээс гадна саван, амны хаалт, гар ариутгагч зэрэг ахуйн хэрэглээний ариун цэврийн бүтээгдэхүүнүүд хэрэгцээтэй байгаа нь дурдагдаж байсан.



Энэхүү үнэлгээ дээр үндэслэн төслийн баг хүнсний багц бэлтгэсэн.




Хүнсний тусламжийн төслийг танилцуулсан, үр шим хүртэгчдийн санал бодол, сэтгэгдлийг харуулсан видео бичлэгтэй дараах холбоосоор танилцах боломжтой.

<https://www.facebook.com/watch/?v=491852935141501>

IRIM судалгааны хүрээлэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хэрэгжүүлсэн уг төслийг санхүүжүүлсэн Give2Asia хандивын сүлжээ, түүний хандивлагчид, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд гар бие оролцсон, хувь нэмрээ оруулсан бүх талуудад талархлаа илэрхийлж байна. Бидний хувьд өөрсдийн судалгаа, үнэлгээний ажилдаа зорилтот бүлгийн иргэдийн дуу хоолой, хэрэгцээ шаардлагыг тусгахыг ямагт эрхэмлэн ажилладаг бөгөөд цаашид ч хүмүүнлэг, хариуцлагатай нийгмийг бүтээхэд өөрсдийн хувь нэмрээ оруулахыг хичээн ажиллах болно.

Бид хүн бүрд тусалж чадахгүй ч, хүн бүр хэн нэгэнд тусалж чадна!

МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЭЦСИЙН ШАТНЫ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Дэлхийн Банк
- Швейцарын Хөгжлийн Агентлаг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү эцсийн шатны үнэлгээний зорилго нь Монгол Улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх (МУНЭХБ) төслийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх явдал юм. IRIM судалгааны хүрээлэн 2016 онд МУНЭХБ төслийн суурь судалгааг гүйцэтгэсэн бөгөөд эцсийн шатны үнэлгээг хийхдээ суурь судалгаатай уялдуулж аргазүй, түүврийн хувьд нийцүүлж, харьцуулагдахуйц байдлаар гүйцэтгэлээ.




2019

11-р сар

2020

4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд болон
Улаанбаатар хот*

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх (МУНЭХБ) төсөл нь ШХА ба ДБ-ны санхүүжилтээр 2015-2019 онд нийт 10 аймаг болон Улаанбаатар хотын 3 дүүрэгт хэрэгжсэн. Төслийн үндсэн зорилго нь ядуурал ихтэй орон нутагт амьдарч байгаа иргэд нийгмийн эгэх хариуцлагын тусламжтайгаар төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцохын зэрэгцээ чанартай үйлчилгээ авах боломжоор хангагдах явдал юм. Тодруулбал, улсын нөөцийн үр нөлөөтэй, ил тод байдлыг дээшлүүлэх болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх зорилготой.

МУНЭХБТ төсөл нь дараах үр дүнд хүрэхээр зорин ажилласан. Үүнд:

- Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх хүрээнд иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд, иргэдийн бүлгүүд, бусад оролцогчид чадавхиж, нийгмийн эгэх хариуцлагын үр дүнтэй арга хэрэгслүүд, стратеги болон нөөцийг өргөжүүлнэ.

- Нийгмийн эгэх хариуцлага нь үндэсний болон нутгийн түвшинд үр нөлөөтэй албажин, тогтвортой байдлаар төлөвшин зохион байгуулагдана (Мэдээллийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, хариу арга хэмжээ авах гэх мэт).

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Тоон ба чанарын судалгааны аргыг хослуулан эцсийн үнэлгээг хийсэн бөгөөд төсөл хэрэгжсэн 8 аймаг, 3 дүүргийг үнэлгээнд хамрууллаа. Үнэлгээний мэдээллийг дараах аргуудаар цуглууллаа. Үүнд:

- Асуумж – 1000 гаруй өрх болон Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын төлөөлөл
- Ярилцлага – ТББ, бодлогын хүрээлэн, төрийн байгууллагын ажилтнууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл
- Бүлгийн ярилцлага – Төслийн оролцогч талууд буюу ИНБ-ууд

- Баримт бичгийн судалгаа - Холбогдох ном, судалгааны баримт бичгийн судалгаа.

Төслийн үр дүнг суурь судалгааны мэдээлэл болон хяналтын бүлэгтэй харьцуулан шинжилж, үр дүнг боловсруулсан байна.

ҮР ДҮН

МУНЭХБ төсөл нь иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжих, чадавхыг бэхжүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд тогтвортой оролцохыг дэмжих, засгийн газрын бодлогын дэвшлийг дэмжиж ажиллав. Нийгмийн эгэх хариуцлагаар дамжуулан ядуурал ихтэй бүс нутагт байгаа иргэд олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад оролцон, чанартай үйлчилгээнд илүү их хамрагдах боломжтой болно.

Төслийн нэгдүгээр зорилтот үр дүн нь ИНБ-уудын нийгмийн хариуцлагыг өргөжүүлэх явдал байв. Судалгааны суурь болон эцсийн шатны

үнэлгээний үр дүнг харьцуулж үзэхэд үр дүнгийн 5 үндсэн үзүүлэлтээс 4 үзүүлэлт нь төслийн зорилгод хүрсэн бол нэг нь тодорхой хэмжээгээр үр дүнд хүрсэн байна. Төслийн хоёрдугаар зорилтот үр дүн болох нийгмийн хариуцлагыг институтчилэх 2 үзүүлэлт нь зорилтот үр дүндээ бүрэн хүрсэн байна.

ИНБ-уудын 75% нь нийгмийн хариуцлагын талаар ямар нэгэн төсөл өмнөх гурван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн байна. Төслийн үр дүнд нийгмийн хариуцлагын төслүүдийг хэрэгжүүлэхэд ИНБ-ын техник, зохион байгуулалтын чадавх нэмэгдэх зорилттой байсан. Эцсийн шатны үнэлгээнд хамрагдсан ИНБ-уудын 83% нь нийгмийн хариуцлагын төслүүдийг хэрэгжүүлэх техник болон зохион байгуулалтын чадавх сайжирсан гэж мэдэгджээ.

Энэхүү төсөл болон судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг төслийн албан ёсны цахим хуудас болох www.irgen-tur.mn-ээс харна уу.

“ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ” (SPACES) ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ЯВЦЫГ ҮНЭЛЭХЭД АШИГЛАХ ҮР ДҮНД СУУРИЛСАН МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, СИСТЕМ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг зөвлөх үйлчилгээний үндсэн зорилго нь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн санхүүжилтээр Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ) хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” төслийн үр дүнд суурилсан мониторингийн системийг сайжруулах, төслийн явцыг үр дүнтэй, чанартай хэмжих мониторингийн хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулахад оршино. Төслийн багийн мониторингийн талаарх мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх замаар үр дүнд суурилсан мониторингийн систем ашиглалтыг бэхжүүлэхэд голчлон анхаарч төслийг хэрэгжүүлэв.




2020

3-р сар

2020

5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол орны байгалийн олон төрлийн бүс, бүслүүрүүд нь ан амьтан, ургамлын олон зүйлүүдийн амьдрах орчныг бүрдүүлж байдаг. Эдгээр биологийн олон янз байдал нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс юм. Биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд төрөөс нийт нутаг дэвсгэрийнхээ 30 орчим хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөц баялгийн хэт ашиглалт нь хамгаалалттай газар нутгийн сүлжээний биологийн олон янз байдал болон экосистемд эрсдэл учруулсаар байна.

Хөдөөгийн хүн амын нэлээд хэсэг нь тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн орчны бүсэд амьдардаг бөгөөд эдгээр газар нутаг эрсдэлд орсноор тухайн оршин суугчдын амьжиргаанд ч сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. ТХГН-ийн удирдлагын тогтолцоо нь төсөв, санхүүгийн хүрэлцээ хангалтгүй байдлаас шалтгаалан учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж чаддаггүй, түүнчлэн хамгаалалтын захиргаад нь мэргэжлийн

ур чадвар, техникийн боломж, хүн хүчний хувьд ч дутагдалтай байдаг. Иймд ТХГН-ийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийг шат дараалан хэрэгжүүлэх болсон.

SPACES төслийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэн нийт 3 төрлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээг баримт бичгийн судалгаа, SPACES төслийг хэрэгжүүлэгч баг болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага болох БОАЖЯ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах байдлаар гүйцэтгэсэн. Ингэхдээ SPACES төслийн одоогийн байгаа үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сайжруулж нарийвчлах, төслийн гүйцэтгэл, явцыг хянах шалгуур үзүүлэлтүүдийг холбогдох хэрэглэгдэхүүнүүдийн хамт шинээр боловсруулав.

Дүрс 1. Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээ

1. ОДООГИЙН БАЙГАА ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Үр дүнгийн хүрээн дэх одоо байгаа үр дүн, гарцын үзүүлэлтийг хэмжих аргачлалыг шалгуур үзүүлэлтийн гол агуулга, тодорхойлолтыг өөрчлөхгүйгээр санал болгосон.

2. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЯВЦЫГ ХЯНАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Төслийн гүйцэтгэл, явц, ололт амжилтыг хэмжихэд төслийн менежментийн багт дэмжлэг үзүүлэх хяналтын төлөвлөгөө, ашиглагдах хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулсан.

ҮР ДҮН

Зөвлөх үйлчилгээний үр дүнд нийт 38 шалгуур үзүүлэлт бүхий төслийн явц, хэрэгжилт, үр дүнг үнэлэх матриц боловсруулсан. Уг шалгуур үзүүлэлтүүдээс 6 нь жендерийн тэгш байдал, оролцогч талуудын оролцоог үнэлэх шалгуур үзүүлэлт байхаар тусгав.

Үүнээс гадна 38 шалгуур үзүүлэлт тус бүрийн дэлгэрэнгүй тайлбар, суурь болон хүрэх түвшин, мэдээлэл цуглуулах арга/эх үүсвэр, үнэлэх аргачлал, хариуцах эзэн, оролцогч талууд, үнэлгээ хийх давтамж, мэдээллийн задаргаа зэргийг нарийвчилж явцыг хэмжихэд ашиглагдах 11 төрлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулж захиалагч байгууллагад хүлээлгэж өгсөн.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн хүрээнд боловсруулагдсан бүтээгдэхүүнүүдийг чадавх бэхжүүлэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах байдлаар SPACES төслийг хэрэгжүүлэх багт танилцуулсан. IRIM судалгааны хүрээлэнгийн боловсруулсан үр дүнд суурилсан мониторингийн систем болон хэрэглэгдэхүүнүүд нь SPACES төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа гэдэгт бид найдаж байна.

ЗАЛУУЧУУДЫН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Бүгд Найрамдахчуудын Олон Улсын хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг судалгаа нь Монгол Улс дахь ардчилал, хүний эрхийн нөхцөл байдлын талаарх залуучуудын санаа бодлыг судлах үндсэн зорилготой. Үүний хүрээнд үндсэн 3 бүлэг сэдвийн дагуу мэдээлэл цуглуулсан. Үүнд:


- Монгол дахь ардчилсан институтийн нөхцөл байдал, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх залуучуудын санаа бодлыг судлах
- Залуучуудын мэдээлэл авч буй эх үүсвэрийг олж тогтоох, хаанаас хэрхэн мэдээлэл авч байна, түүнийгээ хэрхэн баталгаажуулж байгааг судлах
- Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлагатай байдал, иргэдэд хүрч буй хамрах хүрээний талаарх залуучуудын санаа бодлыг судлах



2020 4-р сар

2020 7-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл аймгууд

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны дизайн нь нэг цаг хугацаанд өргөн хүрээг хамарсан буюу “хөндлөн үргэлжлэх (cross-section)” судалгаа байсан. Мөн уг судалгаа нь залуучуудын ардчилал, хүний эрхийн талаарх санаа бодол, мэдээлэл авч буй эх үүсвэр, арга зам зэргийг олж тогтоох зорилготой “тодорхойлох (descriptive)” төрлийн судалгаа байв.

Судалгаанд хамрагдсан 18-40 насны 2,500 хүнийг түүвэрлэхдээ “давхраат буюу страта” түүврийн аргачлалыг сонгосон.


Судалгааны анхан шатны нэгж нь Улаанбаатар хотод хороод, хөдөө орон нутагт сумд байсан. Орон нутаг бүрээс төлөөлөгдөх түүврийн хэмжээг Үндэсний статистикийн газрын статистиктай уялдуулж тогтоосон. Харин өрх болон өрхийн гишүүдээс судалгаанд оролцогчийг сонгохдоо санамсаргүй түүврийн аргачлал ашигласан.

ҮР ДҮНГҮҮД ЦААШДЫН ЧИГЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэн нь зөвхөн мэдээлэл цуглуулах шатанд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үр дүн, тайлан бэлтгэх шатад оролцоогүй болно. Судалгааны хураангуй үр дүн болон хэвлэлийн мэдээтэй дараах холбоосоор орж танилцах боломжтой.

https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public.pdf

<https://www.iri.org/resource/poll-young-mongolians-shows-enthusiasm-political-inclusion-concerns-over-unemployment>



"АМЬСГАЛАХ ЭРХ" ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Пийпл Ин Нийд (ПИН) ТББ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү төсөл нь Улаанбаатар хот болон Архангай аймагт агаарын бохирдлын мэдээлэл, үйл ажиллагааны талаарх ил тод байдал болон хариуцлагыг нэмэгдүүлж, мэдээллийн хүртээмжтэй системийг бий болгох зорилготойгоор хэрэгжсэн "Амьсгалах Эрх" төслийн хэрэгжилтийг үнэлж, үнэлгээний үр дүнд үндэслэн төслийг сайжруулах санал зөвлөмж боловсруулах үндсэн зорилготой.



2020 1-р сар

2020 6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын төвийн 5 дүүрэг, Архангай аймгийн Цэцэрлэг сум

ТӨСЛИЙН ҮНДСЭЛЭЛ

Улаанбаатар хот өвлийн улиралд ДЭМБ-ын зөвшөөрөгдөх хэмжээг даруй 50 дахин давсан агаарын чанартай байдаг тул дэлхийд агаарын бохирдлоор тэргүүлэгч хотуудын нэгд зүй ёсоор тооцогддог. Жил ирэх тусам нийслэлээс гадна аймаг, сумын төвүүд гэх мэт суурин газруудад ч агаарын бохирдлын асуудал хурцаар тавигдаж байна. Агаарын бохирдол нь нийт хүн амын дунд амьсгал, зүрх судас, уушгины хавдрын өвчлөл үүсэх, нялхсын эндэгдэл, зулбалт, ургийн гаж

хөгжлийг ихэсгэх зэрэг нөлөө үзүүлж нийгмийн эрүүл мэндэд сөрөг үр дагавар авчирсаар байна. Үүнтэй холбоотойгоор “Амьсгалах Эрх” төслийг Пийпл Ин Нийд (ПИН) ТББ санаачлан Европын Холбоо болон АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран 2018 оны 1 сараас 2019 оны 12 сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн. Төсөл нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Дүрс 1. “Амьсгалах Эрх” төслийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд



Манай байгууллага нь “Амьсгалах Эрх” төслийг тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, төслийн урт хугацааны нөлөөлөл, дээр дурдсан үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, авсан арга хэмжээний хэрэгжилт, оролцогч талуудын оролцооны түвшин зэргийг үнэлж, төслийн чанар, нөлөөллийг сайжруулах, цаашид авах арга хэмжээ зэргийг тусгасан санал зөвлөмж боловсруулах үүргийг гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Арга зүйн хувьд төслийн хэрэгжилтийг хагас бүтэцлэгдсэн болон гүнзгийрүүлсэн ярилцлага, баримт бичгийн шинжилгээ зэрэг багтсан Чанарын, төслийн оролцогч талуудаас асуумжид үндэслэн мэдээлэл цуглуулах Тоон аргыг хослуулсан холимог аргаар үнэлсэн. Үнэлгээний төслийн ерөнхий дизайныг гаргахдаа Амьсгалах Эрх төслийн логик хүрээнд үндэслэн Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Хөгжлийн тусламжийн хорооны үнэлгээний доорх 5 хүрээний дагуу шалгуур үзүүлэлтүүд боловсруулсан.

Дүрс 2. ОУЭЗХАХБ-ын Хөгжлийн тусламжийн хорооны үнэлгээний хүрээ



ҮР ДҮН, ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн үр дүнг үнэлэх үнэлгээний нийт 20 шалгуур үзүүлэлтээс 11 нь “биелсэн”, 8 шалгуур үзүүлэлт “биелсэн хэдий ч цаашид сайжруулалт


шаардлагатай”, нэг шалгуур үзүүлэлт “үнэлэх боломжгүй” гэж дүгнэгдсэн. Амьсгалах эрх төсөл хэрэгжсэнээр төслийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн агаарын бохирдлоос өөрийгөө хамгаалах дадалд бодит өөрчлөлт гарсан эерэг үр дүн ажиглагдав.

Тухайлбал, агаарын бохирдол болон түүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаанд хамрагдсан эцэг эх, сурагчдаас нөлөөллийн үйл ажиллагааны өмнө болон дараа авсан судалгааны үр дүнгээс харахад (Дүрс 1 болон 2) судалгаанд оролцогчид агаарын бохирдол дээд цэгтээ хүрдэг өвлийн улиралд долоо хоногийн бараг 5 өдөр амны хаалт зүүж байгаа үр дүн гарсан. Хэрэв эдгээр хүмүүс амралтын өдрүүдэд гэртээ байдаг гэж тооцвол тэд гадуур гарах бүртээ амны хаалт зүүж, гадаад орчны агаарын бохирдолд өртөх эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах дадал суусан гэсэн үг юм. Гэтэл нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжээгүй байсан үед (2019 оны 1-р сар) амны хаалт тогтмол хэрэглэдэг эцэг эх болон хүүхдийн хувь нийт судалгаанд оролцогч эцэг эхчүүдийн 10%, хүүхдүүдийн 31%-ийг эзэлсэн үзүүлэлттэй байжээ. Энэ нь агаарын бохирдлоос хамгаалах сайн туршлагын талаар мэдлэг, дадал нэмэгдсэнийг илэрхийлж байна.

Дүрс 3. Оролцогчдын амны хаалт хэрэглэх дадал (Нөлөөллийн үйл ажиллагааны дараа буюу 2020 оны 3-р сарын байдлаар)




Дүрс 4. Оролцогчдын өвлийн улиралд амны хаалт хэрэглэх дадал (Нөлөөллийн үйл ажиллагааны өмнө буюу 2019 оны 1-р сарын байдлаар)




Үүнээс гадна Дүрс 3 болон 4-т харуулсанчлан, хүүхдүүдийн ханиад болон амьсгалын замын өвчин туссан давтамж 10 гаруй хувиар буурч, ханиад хүрч хүндэрсний улмаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхдийн үзүүлэлт 7 орчим хувиар буурсан эерэг үр дүн гарчээ. Эцэг эхчүүд агаарын бохирдол ихтэй үед хүүхдүүддээ хамгаалах амны хаалт зүүлгэх, 5-аас доош насны хүүхдийг өргөж явах зэрэг дадлууд нь уг өөрчлөлтөд дам байдлаар нөлөөлсөн байх магадлалтай.

Дүрс 5. Өвлийн улиралд ханиад, хүүхдүүдийн амьсгалын замын өвчин туссан давтамж, хувиар



Дүрс 6. Ханиад хүрч хүндэрсний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдийн хувь



Өвлийн улиралд гэртээ агаар цэвэршүүлэгч ашигладаг өрхийн тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй. Гэсэн хэдий ч Хүснэгт 1-т үзүүлсний дагуу төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, олон нийтийн оролцооны үйл ажиллагааны өмнө хүмүүс агаар цэвэршүүлэгчийг хэрхэн ашиглах, хаанаас худалдаж авах, түүний нөлөө зэргийн талаар мэдлэг, мэдээлэл муутай байв. Сургалтын дараах үнэлгээнээс харахад тэдгээр үзүүлэлт 21 орчим хувиар буурсан үр дүн гарсан.


Хүснэгт 1. Агаар цэвэршүүлэгч хэрэглэхгүй байгаа шалтгаан

Шалтгаан	2019 оны 1 сар (%)	2020 оны 3 сар (%)
Хэтэрхий үнэтэй	31.4	81.3
Яаж хэрэглэхийг мэдэхгүй	17.1	3.1
Хаанаас худалдан авахаа мэдэхгүй	18.6	3.1
Ямар нөлөөтэй талаар мэдэхгүй	27.1	6.3
Бусад	5.7	6.3

Иргэд өртөг өндөртэй тул агаар цэвэршүүлэгчийг гэртээ худалдаж авах боломжгүй хэвээр байсан бөгөөд үүний оронд гэртээ ургамал тарих, чийгтэй цэвэрлэгээ хийх, агаарын бохирдол багатай үед цонх онгойлгож агаар сэлгэх, дархлаагаа дэмжих зорилгоор тэжээллэг чанар сайтай хоол хүнс хэрэглэх зэргээр эрүүл мэндээ агаарын бохирдлоос хамгаалж байна.

Дээрх үр дүнгүүдэд үндэслэн IRIM-ын үнэлгээний багийн зүгээс Амьсгалах эрх төслийн цаашдын тогвортой байдлыг хангах, үйл ажиллагааг өргөжүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтийн оролцоог идэвхижүүлэх чиглэлийн санал зөвлөмжийг боловсруулж хүргэсэн. Үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулсан санал зөвлөмж “Амьсгалах эрх” төслийн цаашдын үйл ажиллагаа, өргөжилтөд эерэг өөрчлөлт авчирна гэж бид найдаж байна.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА-1 БОЛОН 2 ДАХЬ ШАТ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Дэлхийн Банк

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны ажлын гол зорилго нь КОВИД-19 цар тахал хувийн хэвшлийн аж ахуйн нэгж (ААН)-үүдэд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх зорилготой. Дэвшүүлсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Тухайн байгууллагын үйл ажиллагаанд КОВИД-19 цар тахлын үзүүлэх нөлөөллийг илрүүлэхийн тулд утсан болон онлайн ярилцлага хийх,
- 2019 оны Дэлхийн банкны гүйцэтгэсэн Бизнес эрхлэгчдийн судалгаа болон нэгдүгээр шатны судалгаанд оролцсоноос хойш тухайн байгууллагуудын хэд нь үйл ажиллагаагаа бүр болон түр хугацаагаар зогсоосныг илрүүлэх




ЭХНИЙ ҮЕ ШАТ:

2020 6-р сар **2020** 8-р сар

ХОЁР ДАХЬ ҮЕ ШАТ:

2021 1-р сар **2021** 2-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улсын
21 аймаг
9 дүүрэг

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны арга зүй болон хэрэглэгдэхүүнийг Дэлхийн Банк боловсруулсан бөгөөд CATI, CAWI аргаар мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэсэн. Ингэхдээ судалгааны баг аль болох CATI арга буюу утсаар холбогдож ярилцлага хийхийг эрмэлзэж ажилласан ба тухайн байгууллага цаг хугацаа, нөөц боломжийн хувьд утсан судалгаанд оролцох боломжгүй тохиолдолд CAWI буюу онлайн судалгааг авсан.

Дүрс 1-т харуулсанчлан судалгаа 3 үе шаттайгаар явагдсан. Эхлэл шатанд IRIM-ийн зүгээс үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, судалгааны хэрэглэгдэхүүнийг Монгол хэл рүү хөрвүүлэх, асуулгын форм бэлдэх гэх мэт мэдээлэл цуглуулалтын бэлтгэл ажлуудыг хийсэн бол мэдээлэл цуглуулалтын шатанд давхар чанарын хяналтыг хийж байсан. Харин төгсгөл үе шатанд техникийн тайлан болон дата мэдээллийг боловсруулж илгээсэн.

ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

2019 оны Бизнес эрхлэгчдийн судалгаанд хамрагдсан нийт 360 байгууллагаас 1 дүгээр зорилтын хүрээнд:

- Эхний шатны судалгаанд 284 байгууллагатай
- Хоёр дахь шатны судалгаанд 323 байгууллагатай тус тус ярилцлага хийсэн.

Үе шат тус бүрийн үр дүнгээс харахад 2 дугаар зорилтын хүрээнд:

- Эхний шатны судалгааны үед (2020 оны 6-8 дугаар сард) нийт байгууллагын 7.5 хувь нь COVID-19 цар тахлаас үүдэн үйл ажиллагаагаа түр, 8.3 хувь нь бүр мөсөн хаасан бол
- Хоёр дахь шатанд (2021 оны 1-2 дугаар сард) 16.7 хувь нь үйл ажиллагаагаа түр, 28 хувь нь бүр мөсөн хаасан байна.

Дүрс 1. Судалгааны үе шат

Эхлэл шат	Мэдээлэл цуглуулалтын шат	Төгсгөл шат
<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэх • Холбогдох материалуудыг орчуулах • Мэдээлэл цуглуулалтад бэлтгэх 	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл цуглуулалтыг хийх • Чанарын хяналт хийх • Өдөр тутмын тайлан илгээх 	<ul style="list-style-type: none"> • Тоон дата үүсгэх, цэвэрлэх • Боловсруулалт хийх, техникийн тайлах бэлтгэх • Захиалагч руу эцсийн бүтээгдэхүүнийг илгээх

ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



CONSEIL SANTÉ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Эрүүл Мэндийн Яам
- Азийн Хөгжлийн Банк

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Төслийн зорилго нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг таван дагалдах баримт бичгүүдийн хамт боловсруулах явдал юм. Үүнд, (i) Тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багц, (ii) Дунд хугацааны зардлын хүрээ (2019-2024), (iii) Дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Худалдан авах үйл ажиллагааны явц (iv) Тусламж, үйлчилгээний төлөвлөлтийн хүрээ (2019-2024) (v) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ (2019-2024) багтана.



2018 4-р сар

2020 10-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улсын 21 аймаг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газар Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2019-2026)–г боловсруулахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төслийг Азийн Хөгжлийн Банк (АХБ), Японы Ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Техник туслалцааны төсөл нь 2026 он хүртэлх төлөвлөгөөг боловсруулах явцад ЭМЯ-ны хүний нөөцийн болон байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр ЭМЯ нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 дахь эрүүл мэндийн зорилгод хүрэх эрүүл мэндийн салбарын хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой болно.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү төслийн хүрээнд олон төрлийн арга зүйг ашиглан зорилтот үр дүнд хүрэхээр зөвлөх баг ажилласан. Тэдгээрээс олон талт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах аргыг түлхүү ашигласан. Ингэхдээ салбар бүрийн төлөөллийн оролцоог тэгш хангаж, хэлэлцүүлгийн үр дүнг тухай бүрт нь холбогдох баримт бичгүүдэд тусгаж байв. Мөн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудад албан ба албан бус сургалтаар салбарын төлөвлөлт, зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг уялдуулсан. Сургалт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон санхүүгийн төлөвлөлт, эрүүл мэндийн үр нөлөө, технологи, хэрэгцээний үнэлгээ, хөрөнгө оруулалт ба хөрөнгийн төлөвлөлт, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, түүнчлэн салбарын зээл, тусламжийн зохицуулалт зэрэг сэдвийг хамарсан юм.

ҮР ДҮН

Төслийн зорилго нь 2019-2026 онд Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явдал байсан. Иймд уг төлөвлөгөө нь эрүүл мэндийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн 8 чиглэлийн хүрээнд боловсруулагдсан. Төслийн хүрээнд нийт 40 гаруй зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Үүнд бүсийн уулзалт хоёр удаа, үндэсний уулзалт гурван удаа, сэдэвт уулзалтуудыг давхардсан тоогоор 700 гаруй оролцогчдыг хамруулан зохион байгууллаа. Уулзалтад ЭМЯ, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн болон төрөлжсөн эмнэлгүүд, мэргэжлийн холбоод, холбогдох яамд, Монгол Улсад суугаа гадаадын элчин сайдын яамд болон олон улсын донор байгууллагуудын төлөөлөгчид, бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүд оролцож баримт бичигт саналаа өгсөн. Түүнчлэн ЭМЯ-ны сайдын тушаалаар батлагдсан эдгээр

баримт бичгүүдийг тархаах хүрээнд салбарын бодлого, шийдвэр гаргагчид, мэргэжилтнүүдэд чадавх бэхжүүлэх сургалтыг 2020 оны 9-өөс 10 дугаар сарын хооронд зохион байгуулснаар төслийг амжилттай хэрэгжүүлж дууслаа.



"КОВИД-19 ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ"-ИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- “Гүүд Нэйборс Монгол” Олон Улсын Төрийн Бус Байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

КОВИД-19 цар тахлыг даван туулах чадавхыг бэхжүүлэх төслийн үнэлгээ хийх зорилго нь төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд тусгагдсан зорилго, түүний зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд шаардагдах төслийн үр шим хүртэгчдийн нөхцөл байдлыг харуулахууц суурь мэдээллээр хангах юм.

Үүний тулд үнэлгээний ажил нь дараах зорилтуудад хүрэхээр төлөвлөсөн:

- Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд заагдсан суурь мэдээллийг цуглуулах;
- Төслийг амжилттай хэрэгжсэн эсэхийг үнэлэхэд учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд өгөгдсөн зорилго, зорилтын түвшин дэх төлөвлөсөн зорилтот үзүүлэлтүүдэд хүрэх боломжтой эсэх, бодитой эсэхийг баталгаажуулах;
- Шалгуур үзүүлэлтийг биелэлтийг дүгнэхэд нэмэлтээр ашиглаж болох мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох.

Мэдээлэл цуглуулалтын үр дүнд үндэслэн тайлан бичих. Үүнд: (а) Зорилтот өрх болон бусад оролцогч талуудын өнөөгийн нөхцөл байдал (б) Төслийн тогтвортой байдал, цаашид өргөжүүлэхэд тулгарч болох бэрхшээл (в) Төслийн явцад үүсэж болох бэрхшээл, эрсдэлийг даван туулах зөвлөмж зэрэг агуулгууд багтана.



2020

8-р сар

2021

2-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын 7 дүүрэг: Багануур, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Улаанбаатар хотын гэр хороолол дахь нэн ядуу, эмзэг бүлгийн иргэдийн КОВИД-19 цар тахлын нөхцөлд хариу арга хэмжээ авах чадвар буюу эрсдэлт нөхцөл байдлыг даван туулах чадварыг сайжруулах зорилгоор уг төсөл нь хэрэгжиж байна. Төслийн хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Нэн ядуу, эмзэг бүлгийн иргэдийн (хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг) эрхийг дэмжиж, хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулах
- Нэн ядуу, эмзэг бүлгийн (хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг) хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлж, амьжиргаагаа авч явах чадварыг (эмэгтэй тэргүүлэгчтэй өрх) нэмэгдүүлэх
- Орон нутгийн төрийн байгууллага болон нэн ядуу, эмзэг бүлгийн иргэдийн (хүүхэд, эмэгтэйчүүд) эрүүл мэнд, эрүүл ахуйн чиглэлээр хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулах зэрэг багтана.

Эдгээр зорилтуудын хүрээнд төсөл хэрэгжих хугацаанд төслийн үр шим хүртэгч 7000 өрхөд хүнсний болон эрүүл ахуйн бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлж, 3500 өрхөд “Манай гэр бүл” хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, 2100 өрхөд угаалтуур тарааж, 1000 өрхөд угаалгын үйлчилгээ үзүүлж, 49 эмэгтэйг түр ажлын байраар хангаж, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар (НЭМГ)-т 8600 ширхэг хувийн хамгаалах хэрэгсэл тараах гэх мэт олон талт ажлуудыг зохион байгуулсан байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үр дүнгийн үнэлгээний мэдээллийг цуглуулахдаа тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигласан. Чанарын судалгааны хүрээнд ганцаарчилсан ярилцлага, тоон судалгааны хүрээнд асуумжийн аргыг ашигласан. Төсөлд хамрагдахаар болсон

Улаанбаатар хотын 7 дүүргийн 143 хорооны 7000 өрхөөс түүвэрлэн нийт 543 өрхөөс тоон судалгааны аргаар мэдээлэл цуглуулсан.

ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ

Төсөл нь Улаанбаатар хотын гэр хороолол дахь зорилтот бүлгийн иргэдийн КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд хэрэгжсэн бөгөөд суурь үнэлгээ болон үр дүнгийн үнэлгээнд үндэслэж, төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудад дараах дүгнэлтүүдийг өгч байна.

Манай гэр бүл хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд:

- Манай гэр бүл хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 4 төрлийн агуулга бүхий контент бүтээж, олон нийтэд түгээсэн байна. Үр шим хүртэгчдийн төслийн талаарх сэтгэл ханамж болон 4 төрлийн агуулга бүхий контентыг үзэж өөрийн мэдлэгээ нэмэгдүүлсэн хувь аль аль нь 90-с дээш хувьтай байв. Контентыг олон нийтэд таниулахдаа хүүхдийн сонирхол татахуйц, бүх насныханд зориулсан, олны танил, салбартаа танигдсан мэргэжилтэн нарыг оролцуулсан нь олон нийтэд хүрэхэд чухал нөлөө үзүүлсэн.
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийн талаарх ойлголт, шаардлагатай үед хариу арга хэмжээ авах чадвар суурь үр дүнгээр ердөө 32.6 хувь байсан бол тус хөгжлийн хөтөлбөрт хамрагдсанаар 86.2 хувь болж өссөн нь энэхүү нөлөөллийн ажил нь үр дүнтэй, цаг үеэ олсон ажил болж, цаашид энэ төрлийн нөлөөллийн ажлын хэрэгцээ өндөр байгааг харууллаа.

Хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- Энэ үйл ажиллагааны зорилго нь хоол хүнсээр авах шим тэжээлийн дутагдалтай зорилтот бүлгийн өрхүүдэд хүнсний багц өгснөөр хүнсний хангамжийг нэмэгдүүлэх юм. Өдөр тутмын хоол хүнснээсээ шаардлагатай шим тэжээлээ авч чаддаг өрхийн хувь суурь үнэлгээгээр 47.5 хувь байсан бол үр дүнгийн үнэлгээгээр 84.3 хувь болж өссөн нь хүнсний багц өрхөд бодит дэмжлэг болж чадсан байна. Хоол хүнсэндээ хамгийн их хэрэглэдэг бүтээгдэхүүнд суурь судалгаагаар

гурил, гурилан бүтээгдэхүүн орж байсан тул хүнсний багцад гурилыг оруулж өгсөн нь хэрэгцээтэй бүтээгдэхүүн байж чаджээ. Учир нь зорилтот өрх нь хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг авахаас гадна 3-5 ам бүлтэй өрх нэг сарын хугацаанд гурил, гурилан бүтээгдэхүүнд зарцуулдаг 60,504 төгрөгийг хэмнэсэн байна.

Эмэгтэйчүүдийн амьжиргааг дэмжих үйл ажиллагааны хүрээнд:

- КОВИД-19 цар тахлын улмаас ажилгүй болсон, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг богино хугацааны түр ажлын байраар хангах, орлогыг нэмэгдүүлэх, хоршин хамтран ажиллах ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд 49 эмэгтэйг 7 хоногийн хугацаатай ажлын байраар хангах ажлыг хэрэгжүүлсэн. Ажлын байранд хамрагдахаас өмнө цар тахлаас үүдэн өрхийн орлого нь хэвэндээ байгаа болон нэмэгдсэн өрхийн хувь 65.3 хувь байсан бол түр ажлын байранд хамрагдсаны дараа 87.2 хувь болж өссөн. Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүд ажил олгогч байгууллага, цуг ажилласан эмэгтэйчүүд, өөрийн хийж гүйцэтгэсэн ажил үүрэгт сэтгэл ханамж өндөртэй байгаа бөгөөд цаашид энэ төрлийн төсөлд дахин хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн 5 төрлийн үйл ажиллагаанаас хамгийн их хэрэгцээтэй ба сэтгэл ханамжтай байгаа үйл ажиллагаагаар энэхүү хөтөлбөр үнэлэгдсэн.

Улсын эмнэлэг, төслийн зорилтот бүлгийн өрхөд эрүүл ахуйн багцын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- Тусгаарлалт, ажиглалт болон эрсдэлт бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үүднээс НЭМГ, ЭМЯ-нд хамгаалах хэрэгсэл хандивласан. Энэ үйл ажиллагаа нь хөл хорио бий болохоос хэдхэн хоногийн өмнө хийгдсэн нь цаг хугацааны хувьд маш зөв зүйтэй дэмждэг болсон байна. Цаг үеийн нөхцөл байдал нь эрүүл мэндийн байгууллагуудын хувьд хэвийн бус цар тахлын дэгдэлтийн үе учир дээрх хоёр байгууллагын хамгаалах хэрэгслийн нөөц дутагдалтай, бага хэмжээнд байсан. Хамгаалах хэрэгслийн дэмжлэг үзүүлснээр тус байгууллагуудын нөөцийг тус бүр 20 хувиар нэмэгдүүлж чадсан байна.

- Эрүүл ахуйн нөхцөл хангалтгүй зорилтот бүлгийн өрхүүдийн хувийн эрүүл ахуйн арга хэмжээ авах чадварыг сайжруулах хүрээнд өрхүүдэд эрүүл ахуйн бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлсэн байна. Цар тахлын үед эрсдэлээс сэргийлэх хамгийн түгээмэл 5 төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж буй өрх суурь судалгаагаар 61.2 хувьтай байсан бол үр дүнгийн үнэлгээгээр 90.8 хувь болж өсжээ. Өрхүүд эрүүл ахуйн багцын дэмжлэг авснаар эрүүл ахуйн арга хэмжээ авах чадвар сайжирсан төдийгүй маскийн хэрэглээний талаарх мэдлэг нэмэгдэж, 3-5 ам бүлтэй айл нэг сарын хугацаанд ахуйн бүтээгдэхүүндээ зарцуулдаг 11,710 төгрөгийг хэмнэсэн байна.

Өрхөд угаалгын үйлчилгээ, угаалтуурын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- Төслийн зорилтот үр шим хүртэгчдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн орчныг сайжруулж даван туулах чадамжийг нэмэгдүүлэх хүрээнд өрхүүдэд зориулалтын угаалтуур тарааж, угаалгын үйлчилгээнд хамруулсан байна. Гараа зайлшгүй угаах ёстой 7 тохиолдлыг сонгосон оролцогч болон зориулалтын гар угаалтууртай өрхийн дундаж хувь суурь үр дүнгээр 49.3 хувь байсан бол үр дүнгийн үнэлгээгээр 84.6 хувь болж өссөн

байна. Мөн иргэдийн гар болон шүдээ зөв угаах талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн. Зориулалтын бус угаалтууртай байх үедээ усны зарцуулалт их байх, усаа халааж угаах гэх мэт олон асуудлууд үүсдэг талаар суурь судалгаагаар дурдаж байсан бол зориулалтын угаалтууртай болсноор дээрх асуудлууд шийдэгдэж, өмнөхөөсөө илүү олон удаа гараа угаадаг болжээ. Энэ нь цар тахлын үед зорилтот бүлгийн иргэдийн хариу арга хэмжээ авах чадварыг маш сайн нэмэгдүүлж чадсан гэж үзэж байна.

- Угаалгын үйлчилгээ үзүүлснээр өрхийн эрүүл ахуйн орчин сайжирч, эрүүл ахуйн зөв дадалтай болоход дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн гэрийн ажлыг хөнгөвчлөх зорилгын хүрээнд өрхүүдэд угаалгын үйлчилгээ үзүүлсэн байна. Гэрийн том оврын эд зүйлсээ сүүлийн 3 сард угаасан өрхийн хувь суурь судалгаагаар ердөө 9.3 хувь байсан бол үр дүнгийн үнэлгээгээр 84.6 хувь болж өссөн. Мөн иргэдийн 90-с дээш хувь нь том оврын эд зүйлсээ бохирдсон тохиолдолд угаалгын үйлчилгээгээр үйлчлүүлнэ гэсэн бодолтой байна. Энэ нь эрүүл ахуйн чадамжийг нэмэгдүүлэхээс гадна, эрүүл ахуйн зөв дадалтай болоход дээрх үйлчилгээ нь нөлөөгөө үзүүлж чадсан гэж дүгнэж байна.

“МОНГОЛ ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Корам интернэшнл

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Үнэлгээний ажлын зорилго нь 2016 оны 09 дүгээр сарын 01-ээс Монгол Улсад мөрдөж эхэлсэн Хүүхэд хамгааллын тухай хууль (ХХтХ)-ийн ерөнхий зорилгод хүрэхийн тулд гаргасан алхам, ахиц дэвшлийг үнэлж улмаар хүүхэд хамгааллын тогтолцоотой холбоотой хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах талаар Монгол Улсын Засгийн Газар болон бусад оролцогч талуудын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд оролцогч талуудын цаашид хийж болох алхмуудад зөвлөмж өгөх зорилготой.

Зорилт:

1. Оролцогч талуудын үүрэг хариуцлагыг үр дүнтэй хуваарилах, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулахад ХХтХ ямар хувь нэмэр оруулж буйг судлах
2. Урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний аль алиныг нь харгалзан ХХтХ-д заасан бүх орчин дахь хүүхэд хамгааллын хэрэгцээг хэр түвшинд анхаарч буйг үнэлэх
3. ХХтХ-ийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд МУЗГ-ийн манлайлал, чадавхыг үнэлэх
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээг боловсрол, эрүүл мэнд, мэдээлэл, харилцаа холбоо, технологи зэрэг холбогдох бусад үйлчилгээнүүдтэй нэгтгэх байдлыг судлах




2020

9-р сар

2020

11-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын 2 дүүрэг болон Баян-Өлгий, Өмнөговь Хөвсгөл аймгууд

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Арга зүйн хувьд Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийг хагас бүтэцлэгдсэн болон гүнзгийрүүлсэн ярилцлага, баримт бичгийн шинжилгээ зэрэг багтсан чанарын аргаар үнэлсэн.

ҮР ДҮН, ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төслийн үр дүнг захиалагч байгууллагаас гаргах ба одоогоор эцэслэн гараагүй байна.

Дүрс 1. Ярилцлагад оролцогч талууд



“ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ТҮҮНИЙ 2016–2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ҮНЭЛГЭЭ



ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
- НҮБ-ын Хүн Амын Сан
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
- Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (ТХАХТББ) болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийн биелэлтийг системтэйгээр үнэлэхэд оршиж байна. Үнэлгээний ажил дараах гурван зорилттой:

1. ТХАХТББ, түүний зорилтуудын хүрээнд 2018-2020 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн нийцтэй байдал, уялдаатай байдал, үр дүн, үр ашиг, үр нөлөө, тогтвортой байдлыг үнэлэх;
2. Үнэлгээнээс гарсан үр дүн, сургамжуудыг нэгтгэн дүгнэж, цаашид бодлогын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмж гаргах;
3. ТХАХТББ-ын шинээр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (ХБТУТХ), Алсын хараа 2050 бодлогын баримт бичиг, КОВИД-19 цар тахалтай холбогдуулан Засгийн Газраас авч хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаатай холбогдох уялдаа холбоог хянан, үнэлгээнд суурилсан бодлого, бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл санал болгох.




2020

12-р сар

2021

4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүрэг болон Говьсүмбэр, Хөвсгөл аймгууд

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Тогтвортой хөгжилд чиглэсэн хамтын үүрэг амлалтад хувь нэмэр оруулах, үндэсний бодлогыг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас бүх салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн үндэс суурь болгон “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан. Үүний зэрэгцээ УИХ-аас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (ХБТТУТХ)-ийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 5-р сарын 7-ны өдөр баталсан бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, оролцогчдын эрх үүргийг боловсронгуй болгож, бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт, шинжилгээ хийх механизмыг тусгасан.

Ингэхдээ нэгдмэл ерөнхий зарчмын хүрээнд урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангахыг зорьж байгаа бөгөөд уг хуулийн хэрэгжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2020 оны 45

дугаар тогтоолоор Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Үүний дагуу Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (ТХАХТББ)-ын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх, хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, санал зөвлөмжид үндэслэн ТХАХТББ-ыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлага үүссэний хүрээнд уг төсөл хэрэгжих болсон.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

ТХАХТББ-ын үнэлгээнд Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллагын дэргэдэх Хөгжлийн тусламжийн хорооноос гаргасан Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гол арга зүй болгон баримталж, бодлогын хамааралтай байдал, уялдаа холбоотой байдал, үр дүнтэй

байдал, үр ашигтай байдал, үр нөлөөтэй байдал, тогтвортой байдлыг үнэлсэн.

Үнэлгээний хүрээнд тоон болон чанарын аргыг хослуулан мэдээлэл цуглуулав. Тоон судалгааны хүрээнд нийт 4 төрлийн асуумж боловсруулж захиалагчтай хэлэлцсэний үндсэн дээр хүн амын тоогоороо хамгийн их Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, хамгийн бага хүн амтай Говьсүмбэр, алслагдсан


Налайх дүүргийг сонгосон.

Зорилтот талбаруудад оршин суудаг иргэдээс бага буюу 5-аас доош насны хүүхэдтэй гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний асран хамгаалагч, тэтгэврийн насны ахмад настан, малчин гэсэн бүлгийн 360 төлөөллөөс цар тахлын нөхцөл байдалд уялдуулан утсаар мэдээлэл цуглуулсан. Доорх хүснэгтэд тоон судалгааны түүврийн бүрдлийг нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. Бодлогын үр шим хүртэгчдээс авсан тоон судалгааны түүврийн бүрдэл

Судалгаанд хамруулсан бүлэг	Дүүрэг / Аймаг				Нийт
	Налайх	Сонгинохайрхан	Говьсүмбэр	Хөвсгөл	
Залуу гэр бүл	30	30	15	15	90
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн/асран хамгаалагч	30	30	30	30	120
Ахмад настан	30	30	30	30	120
Малчин	-	-	15	15	30
Нийт судалгаанд хамрагдагчдын тоо					360

Зураг 1. Чанарын судалгаанд хамруулсан оролцогчид



Чанарын судалгааны хүрээнд дээрх дүрсэд харуулсны дагуу бодлого хэрэгжүүлэгч, ОУБ, хүн амын асуудлууд болох ахмад настан, гэр бүл, боловсрол, шилжих хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, эрдэмтэн судлаачдын төлөөллийг хамруулж нийт 61 ганцаарчилсан ярилцлага хийсэн.

ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төслийн үр дүнгийн тайлан боловсруулагдаж дууссан ч захиалагч талаас санал өгч эцэслэх үйл ажиллагаа хийгдэж буй тул үр дүнг эцэслэн олон нийтэд хараахан тархаагаагүй байна.

"ЗАЛУУЧУУДЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН КОРПУС" ХӨТӨЛБӨРИЙН СУУРЬ СУДАЛГАА



МОНГОЛ
ЭКОЛОГИ ТӨВ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Монгол экологи төв

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Уг хөтөлбөрийн суурь судалгааг 2020 оны 11-р сараас эхлэн IRIM судалгааны хүрээлэнгийн баг гүйцэтгэж байгаа ба уг судалгааны хүрээнд хөтөлбөрийн дэд зорилт тус бүрийн суурь нөхцөл байдлыг тодорхойлох, сурагчдыг чадавхжуулахад чиглэсэн олон талт сургалтын хэрэгцээг тодорхойлохыг зорьж байна.



2020 11-р сар

2021 4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот (Налайх дүүргийн 119-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн 12-р сургууль)
Өмнөговь (Гурвантэс ЕБС, Даланзадгад 5-р сургууль)
Ховд (Мөнххайрхан сум ЕБС, Манхан сум ЕБС)

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Экологийн Төв (МЭТ) нь 'Залуучуудын Тогтвортой Хөгжлийн Корпус (ЗТХК)' хөтөлбөрийг 2019-2022 оны хугацаанд хэрэгжүүлж байна. Европын Холбооны санхүүжилттэй хэрэгжиж буй уг хөтөлбөр нь Монгол орны байгалийн болон соёлын өв, нөөц баялгийг зохицуулах, хяналт

тавих, хамтран ажиллах, манлайлах чиглэлээр 15-22 насны залуусын ур чадварыг хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, бие даасан хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн. Уг зорилгын хүрээнд ЗТХК хөтөлбөр нь дараах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:



Эдгээр үйл ажиллагаа нь Ховд, Өмнөговь, Улаанбаатар хотын байгалийн тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн ойр

байршилтай зургаан ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн ахлах ангийн нийт 2105 суралцагчдад чиглэж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаанд хөтөлбөрийн зорилтот орон нутаг болох Ховд, Өмнөговь, Улаанбаатар хотын 6 ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, багш, удирдлага болон орон нутгийн ТХГН-ийн мэргэжилтнүүдийн төлөөллийг хамруулсан. Нийт судалгааны түүврийг нэгтгэвэл 60 ярилцлага, 373 асуумжаар цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байна.

Мэдээлэл цуглуулахдаа судалгаанд дуу хоолой нь бага тусах магадлалтай зорилтот бүлгийн сурагчдыг хамруулах, санал бодлыг тусгахыг баг зорьж ажилласан. Үүний дүнд судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 20% нь төвөөс алслагдмал амьдардаг, малчин өрхийн хүүхдүүд, 4%-д нь амьжиргааны түвшин доогуур зорилтот өрхийн хүүхэд хамрагдсан.


ҮР ДҮН

Хөтөлбөрийн хүрээнд сурагчдад байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдлэгийг олгохдоо дараах үндсэн 5 сэдвийн хүрээнд сурагчдад зориулсан сургалтын контент, модулийг боловсруулж хүргэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Байгаль орчин тогтвортой хөгжил
- Хувь хүний хөгжил, манлайлал
- Технологи ба инновац
- Санхүү ба бизнес, төсөл хөгжил
- Эрүүл мэнд

Дээрх 5 сэдвийн талаарх хөтөлбөрийн зорилтот сургуулийн сурагчдын мэдлэг, хандлага, дадлыг авч үзвэл, ерөнхий дүнгээр нийт сурагчдын 37.6% нь мэдлэг, ойлголттой, 60.5% нь эерэг хандлагатай, 41.5% нь зөв дадал, зан үйлтэй байв.

Дүрс 2. Сурагчдын мэдлэг, хандлага, дадлын үнэлэгдсэн үр дүнгийн нэгтгэл, n=324



Дээрх сургалтын сэдэв бүрээр сурагчдын мэдлэг, хандлага, чадавхад сурагчдын нас, байршил, хүйс зэргээс хамаарсан ялгаатай нөхцөлүүд ажиглагдаж байсан.

Иймд судалгааны баг хөтөлбөрийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор зорилтот орон нутаг бүрд

хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах, харгалзах шаардлагатай нөхцөлүүдийг тодорхойлсон зөвлөмж боловсруулахаар ажиллаж байгаа ба 2021 оны 4 сард тайлан эцэслэгдэхээр төлөвлөн ажиллаж байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХУУЛЬ БУС САНХҮҮГИЙН УРСГАЛЫН ТАЛААР СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Planet GOLD төсөл

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Монгол дахь алтны бичил уурхайн салбарын хууль эрх зүйн орчин, хууль бус санхүүгийн урсгалыг судлах юм. Судалгааны үр дүнд тухайн салбарын үйл ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах бодлогын санал зөвлөмж боловсруулна. Судалгаа нь үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгт хуваагдсан ба үүнд хэд хэдэн асуудлуудыг багтаасан.

(i) Алтны бичил уурхайн хууль, эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдал нь дараах асуудлуудыг хөндсөн. Үүнд:

- Хууль, эрх зүйн хэрэгжилт, үр нөлөө;
- Газар эзэмших, ашиглах зөвшөөрөл;
- Зохион байгуулалтад орох зөвшөөрөл;
- Олборлох зөвшөөрөл, үйл ажиллагаа;
- Алт боловсруулах журам.

(ii) Алтны бичил уурхайн салбарын хууль бус санхүүгийн урсгал нь дараах асуудлуудыг хөндсөн. Үүнд:

- Алт худалдаалах зөвшөөрөл;
- Нэг цэг үйлчилгээний газрын үр нөлөө;
- Алт худалдах шаардлага, үйл явц, татвар;
- Алтны нийлүүлэлтийн сүлжээ;
- Олон улсын туршлага.




2020

4-р сар

2021

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Баянхонгор, Дархан-Уул, Төв аймгууд болон Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс дахь planetGOLD төслийг Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБОС)-ийн санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр (НҮББОХ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж Үйлдвэрийн Хөгжлийн Байгууллага (НҮБАҮХБ) болон Монгол Улсын Байгаль Орчин Аялал, Жуулчлалын Яам (БОАЖЯ), Канад Улсын Алтны Бичил Уурхайн Зөвлөлтэй (АБУЗ) хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл нь албажуулалт, санхүүжилт болон зах зээлд нэвтрэх, технологийн шилжилт болон мэдлэгжүүлэх гэсэн үндсэн үйл ажиллагааны чиглэлээс бүрдэнэ.

Монгол Улсын Засгийн Газартай хамтран төслийн баг нь орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц, мөнгөн усгүй, цэвэр, үр ашигтай технологи бүхий албажсан бичил уурхайг төлөвшүүлэх таатай орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг судалгаа нь зорилтот 3 аймаг болон Улаанбаатар хотын холбогдох оролцогч

талуудаас чанарын судалгааны аргаар мэдээлэл цуглуулсан. Үүнд:


- Баримт бичгийн судалгаа гүйцэтгэж, судалгааны хүрээнд бодлого, хууль тогтоомж, журмууд болон тайлан, гарын авлагуудад шинжилгээ хийсэн.
- Хагас бүтэцлэгдсэн ярилцлагыг зорилтот талбаруудад үйл ажиллагаа явуулдаг оролцогч талуудтай хийсэн.
- Ганцаарчилсан ярилцлагыг зорилтот талбаруудад үйл ажиллагаа явуулдаг оролцогч талуудтай хийсэн.

Мэдээлэл цуглуулалтыг 2020 онд хийж, мөн баримт бичгийн шинжилгээнд 21 хууль эрх зүйн баримт бичиг, 8 судалгааны тайлан болон бусад холбогдох материалуудтай танилцан, судалсан.

ҮР ДҮН

Энэ судалгааны тайлан нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бэлтгэх явцад эцэслэгдээгүй байсан тул энэ хэсэгт мэдээлэл оруулах боломжгүй байна.

“МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ” ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Японы Хүүхдийг Ивээх Сан

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

IRIM судалгааны хүрээлэнгийн баг уг төслийн үйл ажиллагааны үр дүн, боловсролын салбарын хөгжилд үзүүлсэн үр нөлөөг үнэлэх зорилготой төслийн эцсийн үнэлгээг гүйцэтгэсэн. Энэ хүрээнд:

- ЕБС-д Тэгш хамруулан сургах боловсрол (ТХСБ)-ын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх;
- НТБТ-ийн чадавхыг сайжруулах, боловсролын үйлчилгээний гадна байгаа хүүхдүүдэд боловсрол олгоход чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх;
- ТХСБ-ын талаар эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн мэдлэг, ойлголтод гарсан ахиц дэвшлийг үнэлэх;
- ТХСБ-ыг дэмжих чиглэлээр төрийн бодлого, зохицуулалтад гарсан өөрчлөлтийг үнэлэх;
- Төслийн хүрээнд олж авсан гол сургамж, тэргүүн туршлагаудыг тодорхойлох;
- Оролцогч талуудад төслийн хүрээнд бий болсон үр дүнг тогтвортой үргэлжлүүлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулах ажлуудыг гүйцэтгэв.



2020

10-р сар

2021

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



- *Өвөрхангай аймаг (Арвайхээр, Уянга ЕБС болон НТБТ)*
- *Ховд аймаг (Буянт сумын ЕБС болон НТБТ)*
- *Улаанбаатар хот (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн ЕБС болон НТБТ)*

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэлхий нийтийн боловсролын чиг хандлагад бүх хүүхэд, тэр дундаа тусгай хэрэгцээтэй хүүхдүүд (ТХХ)-ийн сурч боловсрох эрхийг хангахын тулд ТХСБ-ын зарчмыг улс орнууд боловсролын тогтолцоондоо нэвтрүүлэхийг санал болгож байна. Монгол Улс энэ жишгийн дагуу тусгай сургуулиудыг нэмэхээс илүү улсын сургуулийн ердийн ангид ТХХ-ийг элсүүлэн тэгш хамруулан сургах бодлогыг баримталж байна.

Засгийн газрын бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжих зорилгоор 2018 оны 3-р сараас Японы Гадаад хэргийн яамны санхүүжилттэй “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсрол тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийг 2018-2021 оны хугацаанд Японы Хүүхдийг Ивээх Сан хэрэгжүүлээд байна. Уг төсөл нь Нийслэлийн гурван дүүрэг, орон нутгийн хоёр аймгийн 16 ерөнхий боловсролын сургууль (ЕБС), долоон насан туршийн боловсролын төв (НТБТ)-ийн сургалтын орчныг сайжруулах, багшийн арга зүйг дэмжих, олон нийт, оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх замаар ТХСБ-ын тогтолцоог дэмжих зорилготой хэрэгжсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн үнэлгээг Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Хөгжлийн тусламжийн хорооны боловсруулсан (OECD-DAC) үнэлгээний гол шалгуур үзүүлэлтүүд болох: хэрэгцээнд нийцсэн байдал, үр дүнтэй, үр ашигтай, тогтвортой байдал болон үр нөлөөтэй байдал гэсэн 5 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн. Үүнд:

1. **Уялдаа хамаарал**- Төсөл нь салбарын нөхцөл байдал болон зорилтот бүлгийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн эсэх
2. **Үр дүнтэй байдал**- Төсөл нь тэгш хамруулах боловсролыг дэмжих чиглэлээр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх
3. **Үр ашигтай байдал**- Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо болон талуудын хамтын ажиллагаа үр ашигтай байсан эсэх
4. **Тогтвортой байдал**- ТХСБ-ын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн төслийн үйл ажиллагаа нь тогтвортой үргэлжлэх нөхцөлөө хангасан эсэх
5. **Үр нөлөөтэй байдал**- Төсөл нь тэгш хамруулах боловсролын тогтолцоог бий болгоход үр нөлөө үзүүлсэн эсэх зэрэг асуултаудад үнэлгээгээр хариулт өгөхийг зорьсон.

Судалгааны арга:

Үнэлгээнд Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Өвөрхангай, Ховд аймгийн 21 ЕБС (16 зорилтот, 5 хяналтын), зургаан НТБТ-ийг хамруулсан. Ингэхдээ төслийн үр шим хүртэгч, оролцогч талууд болох (1) анхан шатны түвшинд сургууль, НТБТ-ийн захирал, менежер, багш, эцэг эх, сурагчид, (2) дунд шатанд зорилтот дүүрэг болон аймгийн боловсролын газрын мэргэжилтнүүд, (3) шийдвэр гаргах түвшинд Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (БШУЯ), Насан туршийн боловсролын үндэсний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын төлөөллийг оролцуулсан нийт 63 ганцаарчилсан ярилцлага, 653 асуумж цуглуулж, дүн шинжилгээ хийв.

ҮР ДҮН

1.Төслийн уялдаа, хамаарал- Төсөл нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхлэхээс өмнө зорилтот сургууль, НТБТ-ийн дунд 2018 онд Хэрэгцээ тодорхойлох судалгааг гүйцэтгэж, судалгааны үр дүнг төлөвлөлтдөө тусгасан байв. Үүнээс гадна төсөл үйл ажиллагаагаа жил тутмаар төлөвлөж, хэрэгжилтийнхээ явцад оролцогч талуудаас гарсан саналуудыг үйл ажиллагаандаа тусгаж, уян хатан байдлаар ажиллаж ирсэн нь оролцогч талуудын бодит хэрэгцээ шаардлагад төслийн үйл ажиллагааг нийцүүлэхэд чухал алхам болсон байна. Үнэлгээнд хамрагдсан нийт оролцогч талуудын 98% нь төсөл тэдний хэрэгцээнд бүрэн нийцсэн ажлууд хэрэгжүүлсэн гэж үнэлсэн.

2.Үр дүнтэй байдал-Төсөл нь төлөвлөсөн дөрвөн зорилтынхоо хүрээнд дараах үр дүнд хүрсэн байна:

Үр дүн 1. Төслийн зорилтот сургуулиудад ТХСБ-ын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах: ТХХ болон ТХСБ-ын талаарх багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл нь зорьсон үр дүндээ хүрч чадсан. Нэгдүгээр зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан багш нарын сэтгэл ханамж өндөр байснаас гадна багш нарын ТХХ-тэй ажиллах бэлэн байдал, заах арга зүйн талаар мэдлэг, ойлголт, ур чадварууд нь сайжирсан байв. Тухайлбал, зорилтот сургуулийн багш нарын ТХХ, түүнийг онцлог хэрэгцээнд

нийцүүлсэн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах, ТХСБ болон бусад оролцогч талуудын үүрэг оролцооны талаарх мэдлэг, ойлголт нь хяналтын сургуулийн багш нартай харьцуулахад 4-5 дахин өндөр байв. Мөн багш нарын ГСТ-г хэрэгжүүлж ажиллах байдал 2018 оны Хэрэгцээ тодорхойлох судалгааг гүйцэтгэх үед 43% байсан бол уг үнэлгээгээр энэ үзүүлэлт 71% болж өсчээ.

Үр дүн 2. ТХХ-ийг дэмжих, сургууль завсардсан хүүхдүүдийг боловсролд хамруулахад НТБТ-ийн чадавхыг сайжруулах: НТБТ-ийн багш нарын ТХХ-тэй ажиллах мэдлэг, хандлага, чадварыг сайжруулахад чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох сургалтуудыг зохион байгуулсан нь НТБТ-ийн чадавхыг бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал: (1) ТХХ-ийг илрүүлэх, таних (2) тэдгээр хүүхдүүдтэй харилцах, (3) холимог бүлгээр хичээл заах (4) ТХХ-ийн онцлог, тусгай хэрэгцээнд тохируулж сургалтыг зохион байгуулах (5) НТБТ болон ЕБС-ийн суралцагчид хамтдаа оролцсон хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах, (6) эцэг эхчүүдтэй хамтран ажиллах тал дээр багш нарын үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан.

Мөн хоёрдугаар зорилтын хүрээнд боловсролын гадна үлдсэн, сургууль завсардсан хүүхдүүдийг илрүүлэх, бүртгэх зорилготой судалгааг хэрэгжүүлсний дүнд сургуулийн гадна буй нийт 729 хүүхдийг илрүүлсэн. Төслийн эцсийн үр дүнг авч үзвэл, тэдгээр хүүхдүүдийн 50 хувийг нь харьяа орон нутгийн ЕБС, НТБТ болон тусгай сургуульд хамруулж үлдсэн хэсэг хүүхдүүдэд гэрээр боловсрол олгох сургалтыг хэрэгжүүлжээ.

Үр дүн 3: ТХСБ-ыг дэмжихэд эцэг эх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах: Тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа нь эцэг эхчүүдэд ТХСБ-ын талаар мэдлэг, ойлголт өгөх олон талт сургалтууд зохион байгуулсан явдал юм. Үнэлгээнд хамрагдсан эцэг эхчүүдийн 90% нь нэг болон түүнээс дээш удаагийн сургалтад хамрагдсан ба үнэлгээний үр дүнгээр ТХСБ-ын ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт нь 2018 оны Хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүн (6.9%)-тэй харьцуулахад (93.6%) огцом өссөн байна.

Үр дүн 4. ТХСБ-ын талаар баримтлах бодлогыг сайжруулах: 2018-2020 онд БШУЯ-аас ТХСБ-ыг дэмжсэн, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой

дараах гурван гол журмыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг дэмжихэд төсөл онцгой хувь нэмэр оруулсан. Үүнд:

- БСШУС-ын сайдын 2019 оны А/292 тушаал. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”,
- БСШУ-ын сайдын 2020 оны А/249 тушаал. “ЕБС-ийн Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”
- БСШУ-ны сайдын 2020 оны А/184 тушаал. “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”

3.Үр ашигтай байдал- Төслийн баг нь төслийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулж, тогтолцооны хувьд удирдлагын хөндлөн болон босоо хамтын ажиллагааны чиглэлийг барьж ажилласан. Үүнд, зорилтот сургуулиудын багш, заах арга зүйн нэгдэл, сургуулийн удирдлага, аймаг, дүүргийн Боловсролын хэлтэс, БШУЯ зэрэг боловсролын тогтолцоо дахь удирдлагын босоо чиглэлийн хамтын ажиллагаанд суурилсан зохицуулалтуудыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлсэн. Хоёрдугаарт, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, төрийн захиргаа зэрэг олон талт байгууллагыг оролцуулсан хамтын ажиллагааны хөндлөн чиглэлийг бий болгосон бөгөөд дээрх талуудын хамтын ажиллагаа төслийн үр дүнтэй байдалд эерэг нөлөө үзүүлсэн байв.

4.Тогтвортой байдал- Төслийн зорилтот ЕБС, НТБТ-дэд бий болсон чадавх, үр дүн нь цаашдаа тогтвортой үргэлжлэх нөхцөлөө тодорхой хэмжээнд хангасан байв. Тухайлбал, ТХХ-ийн боловсролыг дэмжих сургууль, НТБТ-ийн бодлого, сургалтын дүрэм журам шинэчлэгдсэн, багш, ажилтнуудын ТХСБ-ын талаарх мэдлэг, ойлголт, ТХХ-ийг сургах арга зүйн ур чадвар өссөн, орон нутгийн байгууллагуудын хооронд идэвхтэй хамтын ажиллагаа бий болсон зэрэг голох үр дүнгүүд гарсан. Мөн эдгээр өөрчлөлтийг дэмжих бодлогын түвшний баримт бичгүүд батлагдсан нь төслийн хүрээнд бий болгосон үр дүнг цаашид тогтвортой хадгалахад эерэг нөлөөтэй байна.

5.Үр нөлөөтэй байдал- ТХСБ-ыг дэмжих чиглэлээр олон талт байгууллагын хамтын ажиллагаа, ялангуяа төлөвлөлтийн шатны уялдаа

холбоо сайжирсан. Тодруулбал, төслийн хүрээнд хэрэгжүүлсэн олон төрлийн харилцаа холбоо, мэдээлэл түгээх арга, сувгуудаар дамжуулан ТХСБ-ыг дэмжих чиглэлээр оролцогч талуудын харилцаа холбоо босоо ба хөндлөн урсгалынхаа дагуу сайжирсан байв.

Мөн цахим болон хэвлэмэл байдлаар бэлтгэсэн сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүйн материалууд, ном, сурах бичгүүдийг боловсруулж, ТХХ-ийн бүртгэл мэдээлэлтэй холбоотойгоор Боловсролын удирдлагын мэдээллийн системийн бүртгэл мэдээллийг сайжруулсан нь ТХСБ-ыг дэмжихэд оруулсан чухал хувь нэмэр болсон. Эдгээр нөөцүүд нь оролцогч талуудад хандлагын болон зан үйлийн өөрчлөлтийг бий болгох, цаашид тогтвортой үйл ажиллагаандаа тусгах, уялдаа холбоог хангахад ач холбогдол бүхий төслийн бүтээгдэхүүн болсон.

ДҮГНЭЛТ

Төслийн хүрээнд бий болгосон үр дүнг цаашид тогтвортой хадгалах, сайжруулахад дээрээс доош чиглэсэн бодлогын дэмжлэг хамгийн чухал байна. ТХСБ чиглэлээр БШУЯ-ны баримталж буй бодлогыг харгалзвал төслийн хүрээнд бий болгосон анхан шатны түвшин дэх эерэг өөрчлөлтүүд нь тогтвортой үргэлжлэх, түүнийг дэмжих нөхцөлүүд бүрдсэн. Ялангуяа, төслийн сүүлийн хугацааны хэрэгжилт Ковид-19 цар тахал дэгдсэн үетэй давхардсанаас ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийн үзүүлэлтүүд зайны сургалтын нөхцөлд үндэсний хэмжээнд буурсан. Иймд 2022-2023 оны хичээлийн жилээс сурлагаар хоцрогдсон хүүхдүүд болон ТХХ-ийн боловсролд салбарын яам анхаарал хандуулах шаардлага зүй ёсоор үүсэж буй нь уг төслийн хүрээнд бий болгосон үр дүнг цааш үргэлжлүүлэн хадгалах, дэмжихэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Мөн уг төсөл нь богино хугацаанд хэрэгжсэн хэдий ч олон талын хамтын ажиллагаа, ялангуяа БШУЯ-ны холбогдох төлөөллийг тогтмол үйл ажиллагаандаа оролцуулахаас гадна ТХСБ-ын чиглэлээр ажиллаж буй бусад мэдээллээр хангаж ирсэн нь төсөл дууссан ч түүнээс гарсан ололт, амжилт, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, цаашдын үйл ажиллагаандаа ашиглах, үргэлжлүүлэх мэдээлэл бүхий оролцогч талуудыг бүрдүүлжээ.



“ЦАХИМ МАРАФОН” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Innovation for Change Central Asia
- ARGO Civil Society Development Association
- Tides

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

IRIM судалгааны хүрээлэн Төв Азийн бүсийн 'Innovation for Change' (I4C CA)-тай хамтран 'Цахим Марафон' төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь ил тод байдал, хариуцлага, авлигын эсрэг санаачилгуудыг түгээх дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах шинэлэг, шийдлүүдийг дэмжин ажиллах зорилготой. Мөн төсөлд хамрагдсан багуудын санаачилсан төслөөр дамжуулан урт хугацааны үр өгөөж, үр дүнгээ өгөх боломжтой загварыг богино хугацаанд туршин бий болгоход чиглэнэ.

'Цахим Марафон' төсөл нь үндсэн гурван зорилготой:

- бүтээлч, шинэлэг нийгмийн хөдөлгөөн эсвэл кампанит ажил зохион байгуулах;
- ил тод байдал, хариуцлагын чиглэлээр мэргэжилтнүүдийг чадавхжуулж, тэдний сүлжээг өргөжүүлэхэд нь туслах;
- ил тод байдал, авлигын эсрэг санаачилгуудаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангах, мэдлэгийг нь сайжруулах.



2020

11-р сар

2021

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Афганистан, Казахстан, Киргизстан,
Монгол болон Тажикстан.

ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Уг төслийг хэрэгжүүлэх үед дараах үйл ажиллагаануудыг хийв. Үүнд:

1. Бэлтгэл ажил болон нөхцөл байдлын дүн шинжилгээ

Төслийн баг нөхцөл байдлын дүн шинжилгээний тайланд хүний хөгжил, улс төр, нийгэм, эдийн засгийн асуудал, хүний эрх, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн нөхцөл байдалтай холбоотой зорилтот улс орнуудын онцлог бүхий л асуудлыг судалсан. Үүнээс гадна, төслийн зорилтот орнуудад ашиглагдаж буй олон нийтийн сүлжээнүүдийг судалж, төслийн мэдээллийг түгээхэд бэлтгэсэн.

2. “Төв Ази дахь ил тод байдал ба хариуцлагыг дэмжих нь” сургалт

Төслийн багуудаас төслийн саналыг хүлээн авахаас өмнө Монгол, Афганистан, Киргизстан,

Казахстан, Турк, Тажикстан улсуудын нийт 32 оролцогчдыг хамруулсан хоёр өдрийн онлайн сургалтыг явуулсан. Тус сургалтын тухай зарыг холбогдох вебсайт, фейсбүүк, телеграмм гэх мэт сувгуудаар тархааж сургалтад суух цаашлаад өөрсдийн төслийн саналыг ирүүлэх сонирхолтой хүмүүсийг бүртгэн авч сургалтад хамруулсан. Энэхүү сургалтын үеэр мэргэжлийн шинжээчид дараах сэдвээр илтгэлүүд тавьсан:

- Сургалт 1: Хариуцлага ба иргэдийн оролцоо – Д.Амарбаясгалан (Дэлхийн банкны засаглал ба дижитал хөгжлийн дэлхийн практик туршлагын зөвлөх)
- Сургалт 2: Ил тод байдал ба авлигын эсрэг санаачилгуудын Монгол дахь шилдэг туршлагауд – О.Батбаяр (Транспэрэнси Интернэшнл Монгол - Гүйцэтгэх захирал)
- Сургалт 3: Дэлхийн болон бүс нутгийн чиг

хандлага, хөндлөнгөөс нөлөөлөх шинэчлэл – Ц.Батсугар (IRIM-ийн зөвлөх)

- Сургалт 4: Нийгмийн мэдээллийн нөлөө бүхий кампанит ажил зохион байгуулах гарын авлага – Б.Нинжмаа (Вайрал Партнерс ХХК - Бүтээлч захирал)

3. Төслийн санал болон сонгон шалгаруулах үйл явц

Зорилтот орнуудын төсөлд хамрагдах сонирхол бүхий багуудаас төслийн шинэчлэгдсэн хүрээ, нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн төслийн саналыг хүлээн авах талаарх мэдээг боловсруулан нөхцөл байдлын дүн шинжилгээнээс гарсан олон нийтийн сүлжээнүүд болох Фейсбүүк, Телеграм, Одноклассники, болон вэбсайтууд зэрэг түгээмэл платформоор дамжуулан төслийн санал хүлээн авах тухай мэдээллийг зарласан. IRIM-ийн баг 15 багаас төслийн саналуудыг хүлээн аван үнэлэв. Үнэлгээний хорооны бүх гишүүд үнэлгээний хэрэглэгдэхүүнийг боловсруулж үр дүнг нэгтгэсний дараа тус бүр өөрийн үнэлгээг өгсөн. Энэхүү үнэлгээний үр дүнд 6 баг сонгогдсон.

4. Төсөл хэрэгжүүлэлт

Сонгогдсон зургаан баг өөрсдийн төслүүдээ өөрийн орондоо нийт 5 долоо хоногийн турш хэрэгжүүлэв. Энэ хугацаанд баг тус бүрийг IRIM-ын тухайн салбар бүрийн мэргэжлийн зөвлөхүүд менторлож ажилласан. Төслийг хэрэгжүүлэх явцад багууд зөвлөхүүдтэйгээ янз бүрийн олон нийтийн сүлжээг ашиглан идэвхтэй холбогдож зөвлөгөө авч байсан ба долоо хоног бүр зөвлөхүүддээ өөрсдийн үйл ажиллагааг тайлагнаж, тулгарсан бэрхшээл болон гэнэтийн асуудал гарахад байнгын харилцаа холбоотой байв.

5. Эцсийн дүгнэх семинар болон шилдэг хэрэгжүүлэгчид.

Эцсийн семинарт нийт 21 оролцогч оролцож, баг бүр өөрсдийн туршлага, үр нөлөө, үр дүнгээ бусад оролцогчидтой хуваалцан харилцан бие биеэсээ суралцсан. Төслийн баг бүр сүүлийн семинарт 20-25 минут өөрсдийн төслийн тухай танилцуулж, хэлэлцүүлэг, асуулт хариултыг зохион байгуулсан. Сонгон шалгаруулах хороо

сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг боловсруулан, баг бүрийн төслийн санал болон ирүүлсэн эцсийн тайлантай танилцаж, тухайн баг бүх санал болгосон үйл ажиллагаа, хэмжигдэхүйц үзүүлэлтүүдээ биелүүлсэн эсэхэд сайтар дүн шинжилгээ хийсэн. Сонгон шалгаруулах хорооны гишүүдийн нэгдсэн оноог үндэслэн дараах Шилдэг хэрэгжүүлэгчдийг сонгов:

1. Тажикстан Улс - Branch of the NGO “Office of Civil Liberties”
2. Киргизстан Улс - Content Media NGO
3. Тажикстан Улс - Nuri Irfon NGO

ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮД:

Шалгарсан 6 багын үйл ажиллагааг товч танилцуулахад:

1. Афганистан Улс – Integrity watch Afghanistan

Integrity watch Afghanistan байгууллага нь “Төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдал” нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн зорилго нь сургалт, фокус бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах замаар төрийн худалдан авах ажиллагааны янз бүрийн үе шатанд иргэдийг татан оролцуулж, Афганистан улсын худалдан авах ажиллагааны тогтолцоонд хариуцлагыг нэмэгдүүлэх явдал байсан юм.

2. Тажикстан Улс – Нури Ирфон

Нури Ирфон байгууллага нь “Бид авлигыг тэвчихгүй” нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Төслийн зорилго нь оюутнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, флэшмоб хийх, оюутнуудын дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэдлэг олж авах, авлигын шинжтэй сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд уриалсан ба Хужанд их сургуулийн оюутнуудын дунд хүртээмжтэй байдлыг хангах зорилго бүхий үйл ажиллагаа явуулдаг оюутны клуб байгуулсан.

3. Киргизстан Улс – Content media

Content media байгууллага нь “SynergyKG-21” нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн гол зорилго нь орон нутгийн засаг захиргаанаас ил тод харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэхэд оролцох иргэдийн оролцоог сайжруулах юм. Энэхүү

багын үйл ажиллагаа нь үндсэндээ харилцаа холбоо, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ, санал хүсэлтийн механизм, олон нийтийг сурталчлах үйл ажиллагаанд чиглэсэн.

4. Казахстан Улс – Center for Strategic Research "GUMOL"

Энэхүү баг нь "Зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажилд хэр их мөнгө зарцуулдаг вэ?" төслийг хэрэгжүүлсэн. Төслийн зорилго нь мониторинг болон олон нийтийн худалдан авалтын порталаар дамжуулан төрийн байгууллагуудын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх байсан. Төслийн гол зорилтууд нь (i) төрийн худалдан авах ажиллагааны порталд мониторинг хийх, (ii) сонирхсон хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх байв.

5. Монгол Улс – Багачууд хөгжил

Энэхүү баг нь "Эм үү эсвэл хор уу?" нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн гол зорилго нь (i) оролцогчдоос эмийн хэрэглээ, чанарын талаарх мэдээллийг цуглуулах, (ii) эмийн хангамж - тендер шалгаруулалтын талаар мэдээлэх, (iii) эмийн чанар, худалдан авалтад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх хөшүүргийг бий болгох байв. Уг төсөл нь иргэд, эм ханган нийлүүлэгчид хоорондын үл ойлголцлоос зайлсхийх зарчимд суурилсан.

6. Тажикстан Улс– Office of Civil Liberties

Энэхүү баг нь "Авлига" гэх нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн зорилго нь боловсролын салбарт авлигатай тэмцэх, тэдний хүрээлэн буй орчинд авлигын хэргээс урьдчилан сэргийлэх талаарх залуучуудын (сургуулийн сурагчид, оюутнууд) эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх байв. Тус төслийн зорилтот бүлэг нь залуучууд байсан бөгөөд эдгээр хүмүүсийг авлигыг эсрэг байж, түүнтэй тэмцэхэд сургахад чиглэсэн.

ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТАЛУУДЫН ОЙЛГОЛЦОЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ГОВИЙН ЗАГВАР: МОНГОЛЫН ТУРШЛАГЫГ ТӨВ АЗИД



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Их Британи Нэгдсэн Вант Улсын эдийн засаг, нийгмийн судалгааны хороо, Глобал сорилын судалгааны сан хамтран санхүүжүүлэв.

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

- Оксфордын Их Сургууль

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

БНХАУ-ын томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжиж буй Монгол, Киргизстан зэрэг улсад эдийн засгийн хөгжил, нийгмийн хамгааллын хүртээмжийг нэмэгдүүлэх “тогтвортой дэд бүтцийг хөгжүүлэх загвар” боловсруулах зорилготойгоор хэрэгжиж байна.

Төслийн зорилт:

- Дэд бүтцийн бүтээн байгуулалтад талуудын ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх Говийн загвар бий болгож, туршина. Ингэхдээ Монголын Улсын уул уурхайн салбарын туршлагад үндэслэн загварыг хөгжүүлж, Төв Азид нэвтрүүлэх юм. Загварыг БНХАУ-ын “Нэг бүс-нэг зам” (НБНЗ) дэд бүтцийн санаачилга хэрэгжиж буй газруудад ашиглах боломжтойгоор боловсруулахыг зорин ажиллаж байна.
- Дэд бүтцийн томоохон төслүүдийн оролцогч талуудын хоорондох нээлттэй, харилцан итгэлцэл бүхий хамтын ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлохын сацуу түүнийг даван туулах арга замыг судална.
- Иргэд болон засгийн газрын дэд бүтцийн төслүүдийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, сөрөг үр дагаврыг багасгахад шаардлагатай чадавхыг дээшлүүлнэ.



2018

9-р сар

2021

8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол, Киргизстан

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэд бүтцийн томоохон төслүүд эдийн засгийн өсөлт ба хөгжлийн гол суурь болдог ч нийгэм, байгаль орчинд сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй байдаг. Тухайлбал, орон нутгийн иргэд засаг захиргаатай үл ойлголцох; нөөцийн өрсөлдөөнөөс үүдэн нийгмийн итгэлцэл алдагдах; эдийн засгийн өсөлтийн үр шим тэгш бус хуваарилагдах; засаглал ба институтын чадавх бэхжихгүй байх; байгаль орчны тогтвортой байдал алдагдах; оролцогч талуудын хоорондын зөрчлөөс үүдэн эдийн засгийн үр өгөөж буурах зэргийг дурдаж болно. Эдгээр нийтлэг асуудал тухайн орон нутаг болон түүний газарзүйн онцлогоос хамаарч өөр өөр нөхцөл байдлыг үүсгэдэг. Тиймээс Говийн загвар төсөл эдгээр асуудлыг Төв Ази дахь санаачилгууд, тэр дундаа Нэг Бүс Нэг Зам төслийн хүрээнд нарийвчлан судална.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг төслийн хүрээнд тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг бий болгоход талууд хоорондын зөрчлийг бууруулах, ойлголцол ба хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд засаглалын ямар арга тохиромжтой болохыг олон талт аргаар судалж байна. Монголын баг энэ хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд суманд 'Гурван талт зөвлөл'-ийн оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд ашигласан арга, туршлагын кейсийг судална. Кейс судалгааны үр дүнг "Говийн загвар"-ыг боловсруулахад ашиглах бөгөөд боловсруулсан загвараа Киргизстан, Тажикстан улсад туршина.

Төслийн хүрээнд эрдэм шинжилгээний бүтээлүүдээс гадна вэбсайт, гар утасны аппликейшн боловсруулж, Монгол, Киргизстаны олон төрлийн талуудад ашиглуулна.

ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн баг Монгол Улс (МУ)-ын гурван орд (Ханбогд, Сүхбаатар, Гурвантэс сум) газар, Киргизстаны гурван орд (Ала-Бука, Нарин, Чаткал дахь) бүхий 6 газарт тус тус анхны судалгаагаа хийгээд байна. Монгол Улсад нийтдээ 190 ганцаарчилсан ярилцлага (ГЯ), 8 фокус бүлгийн ярилцлага (ФБЯ) хийсэн бол Киргизстанаас 304 хүнийг (173 ГЯ, 131 оролцогчтой 33 ФБЯ) судалгаандаа хамрууллаа. Мөн энэхүү төсөл Монголын 'Хил хязгааргүй алхам' ТББ-тай хамтран МУ-д уул уурхайн салбарын нийгмийн нөлөөллийн үнэлгээний анхны ажлын хэсгийг байгуулсан. Манай хамтарсан баг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн уул уурхайн ордуудад өргөн хүрээтэй судалгаа, зөвлөгөөн хийж, анхны Монголын уул уурхайн нийгмийн нөлөөллийн үнэлгээний удирдамжийг боловсруулан Монгол Улсын Засгийн газарт танилцуулав. Энэхүү талбарын судалгаагаар зөрчлийн менежмент, компанийн нийгмийн хариуцлага, уул уурхайн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, мэдлэгийн үйлдвэрлэл ба уул уурхайн хөгжлийн мөн чанарын талаарх мэдээлэл солилцох, авлига, уул уурхайн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн талаарх чухал ач холбогдолтой шинэ мэдлэгийг олж авсан юм. Энэхүү мэдлэг, туршлагыг хөдөө орон нутгийн иргэдэд хүртээмжтэй болгох үүднээс уул уурхайн үйл ажиллагаа, үйл явцын талаарх мэдээлэл солилцох аппликэйшн бүтээх тал дээр бид төвлөрөн ажилаж байна.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний судалгаагаар орон нутгийн шийдвэр гаргах үйл явцын талаар илүү нарийн ойлголттой болсон нь албадан нүүлгэн шилжүүлэлт, малчдыг айлган сүрдүүлэх тохиолдлуудыг илрүүлж, уул уурхайн компаниудын нүүлгэн шилжүүлэлт, орон нутгийн өрхүүдэд нөхөн олговор олгох үйл ажиллагааны дүр төрхийг нарийвчлан харуулсан. Энэхүү судалгааны үр дүнг МУ-ын Уул уурхай,

хүнд үйлдвэрийн яам, Киргизстан Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Аж үйлдвэр, эрчим хүч, газрын хэвлий ашиглалтын хорооноос ихээхэн сонирхож байна.

Төслийн өнөөг хүртэл хүрсэн томоохон ололт бол судалгааны чадавхыг нэмэгдүүлэх явдал байлаа. Төслийн хүрээнд Оксфордын баг Монголд 9, Киргизстанд 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эдгээр сургалтад Монгол, Киргизстан, Афганистан улсаас их дээд сургуулийн оюутнууд, эрдэм шинжилгээний ажилтнууд, бие даасан судлаачид, ТББ-ын албан хаагчид, төрийн албан хаагчдын төлөөллүүд хамрагдлаа. Сургалт нь чанарын судалгааны аргууд, академик бичих ур чадвар, чанарын мэдээллийг кодлох, дүн шинжилгээ хийх, судалгааны ёс зүй, судалгааны тэтгэлэгт хамрагдах зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

Мөн МУ-ын уул уурхайн салбар болоод нотолгоонд суурилсан сайн туршлагыг нутагшуулах чиглэлд тулгарч буй бэрхшээл, боломжуудын талаар хэлэлцэх зорилгоор уул уурхайн компаниуд, яамд, хуулийн фирмүүд, ТББ-уудын төлөөллийг оролцуулсан мэдлэг солилцох цуврал арга хэмжээнүүдийг зохион байгуулаад байна.

ХЭВЛЭГДСЭН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛЭГҮҮД:

- Lezak S, Ahearn A, McConnell F, Sternberg T. (2019). Frameworks for conflict mediation in international infrastructure development: A comparative overview and critical appraisal. *Journal of Cleaner Production*, doi: 10.1016/j.jclepro.2019.118099
- Sternberg T, Ahearn A, McConnell F. (2019). From conflict to a Community Development Agreement: a South Gobi solution. *Community Development Journal*, doi: 10.1093/cdj/bsz018

"МОНГОЛ НОГОО" ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА – 2020



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra



Food and Agriculture
Organization of the
United Nations



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Швейцарын Хөгжлийн Агентлаг
- Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо
- НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуй нэгж, иргэд болон өрхийн хүнсний ногооны тариалалтын одоогийн нөхцөл байдал, техникийн нөхцөл шаардлага, сүүлийн жилүүдэд гарч байгаа өөрчлөлтүүдийг нарийвчлан судлахад чиглэсэн. Энэхүү судалгааны ажлын хүрээнд төслийн дараах 4 зорилгыг үнэлсэн. Үүнд:

Үр дүн 1: Дотоодын хэрэглээгээ хангахын тулд хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хөдөө орон нутаг болон хот орчмын жижиг тариалан эрхлэгчид, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн амьжиргааг сайжруулах

Үр дүн 2: Дотоодын хүнсний ногооны маркетинг (үүнд жижиг тариалан эрхлэгчид, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг оролцуулаад) сайн зохион байгуулалттай, зах зээлийн чиг хандлага, хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн, ашиг орлого сайтай болсон байх ба үүнд анхан болон хоёрдогч хоршоод гол үүрэг гүйцэтгэх

Үр дүн 3: Тариалан эрхэлдэг байгууллагуудын (үүнд хүнсний ногооны үрийн үйлчилгээний нэгж орно) зохион байгуулалтын хөгжил, засаглалын бүтэц, санхүүгийн менежментийг бэхжүүлэх

Үр дүн 4: Хүнсний ногооны салбарын тогтвортой, өсөлтөд байдал нь бодлого/хууль эрх зүй болон институтийн орчны сайжралтаар дэмжигдэх.



2020 3-р сар

2020 6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Австрали Улсын Засгийн Газар, Гадаад Хэрэг Худалдааны Яамнаас (ГХХЯ) санаачлан санхүүжүүлдэг, Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрөөс Зориг сантай түншлэн Эмэгтэйчүүдийн Манлайллын Хөтөлбөрийг (ЭМХ) хэрэгжүүлдэг. ЭМХ нь Австралийн Засгийн Газраас Монгол Улсын хөгжилд үзүүлдэг туслалцааны нэг хэсэг бөгөөд 2014 оноос хойш Австрали Улсад магистр болон докторын зэргээр суралцаж төгссөн төгсөгчдийг хамруулан хэрэгжсээр байна. Хөтөлбөрийн 2020 оны оролцогчдоос энэхүү үнэлгээг гүйцэтгэх хүсэлтийг ирүүлсэн юм. Засаглал, үйл ажиллагааг үнэлэх хүрээнд тус нийгэмлэгийн төлөөлөл болох гүйцэтгэх удирдлага, нийгэмлэгийн гишүүд болон хамтрагч байгууллага, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төгсөгчдийн холбооны төлөөллийг хамруулсан.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Монгол – Австралийн Нийгэмлэгийн засаглал, үйл ажиллагаанд өмнө нь хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаагүй учраас харьцуулах суурь дата байхгүй. Тиймээс уг үнэлгээнд нийгэмлэгийн дүрмийг гол баримт бичиг болгон ашигласан. Мэдээлэл цуглуулах болон боловсруулах шатанд дараах холимог аргуудыг ашигласан.

1. Тоон судалгаагаар нэгд, нийгэмлэгийн засаглал, бүтэц зохион байгуулалтын талаарх гишүүдийн мэдлэг, удирдлагын багийн

ажлын гүйцэтгэл, түүний үнэлгээ, бүтэц, зохион байгуулалттай холбоотой өөрчлөх санал; хоёрт, нийгэмлэгийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ, гишүүдийн нийгэмлэгээс хүлээж буй хүлээлт, гишүүдийн хэрэгцээ, шаардлага, тэдний цаашид үйл ажиллагаанд оролцох оролцоог тус тус тодорхойлсон.

2. Баримт бичгийн судалгаагаар, Монгол – Австралийн Нийгэмлэгийн олон нийтэд болон үнэлгээний багт нээлттэй бодлогын баримт бичгүүдтэй танилцаж 4 төрлийн шинжилгээ хийсэн;
3. Чанарын судалгаагаар нэгд, нийгэмлэгийн засаглал, бүтэц зохион байгуулалтад тулгамдаж буй асуудал, учир шалтгаан болон сайжруулах санал; хоёрт, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын засаглал, үйл ажиллагааны сайн туршлага зэргийг тус тус тодорхойлсон.

Үнэлгээний хүрээнд нийт 18 чанарын ярилцлага, 56 тоон судалгааны асуумж цуглуулж, мэдээлэлд боловсруулалт, дүн шинжилгээ хийн захиалагч талд эцсийн тайлан болон холбогдох санал зөвлөмжийг хүргүүлсэн.

ҮР ДҮН

Уг ажил нь тус байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, олон нийтэд чиглэсэн үр дүнг гаргаагүй тул тодорхой мэдээлэл оруулах тохиромжгүй юм.

Энэхүү дизайны дагуу гүйцэтгэж буй суурь судалгаа нь төслийн суурь мэдээллийг цуглуулж байгаа бөгөөд мэдээлэл нь хугацааны хувьд хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц байх зарчимд голлон анхаарсан.

Суурь судалгаанд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг болон 5 аймгийн 8 сумдын 360 өрх хамрагдсан. Мөн зорилтот

сумдын ХАА-н асуудал хариуцсан төрийн байгууллагын албан хаагчид, хүнсний ногоо борлуулагчид зэрэг нийт 35 хүн ганцаарчилсан ярилцлагад оролцож, 15 цэцэрлэг, 13 сургуулийн хүлэмж, хоолны цэсэнд ажиглалт хийлээ.

Доорх зурагт судалгааны нийт хүрээг тоймлон харуулав.

МОНГОЛ НОГОО ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА

Тоон судалгаа:		Чанарын судалгаа:	
Баримт бичиг	Анкет судалгаа	Ярилцлага судалгаа	
<p>Төслийн баримт бичгийн тойм судалгаа</p> <p>Хүнсний ногооны салбарын статистикийн тойм судалгаа</p>	<p>Судалгааны арга: Асуумж судалгааны дагуу нүүр тулсан ярилцлага</p> <p>Оролцогчид: Төв аймгийн Борнуур, Жаргалант, Дархан-Уул аймгийн Орхон, Орхон аймгийн Жаргалант, Увс аймгийн Улаангом, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Мандал, Шаамар сумдын 360 өрх</p>	<p>Судалгааны арга: Асуумжийн дагуу нүүр тулсан ярилцлага</p> <p>Оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн ЗДТГ-ын ХАА холбогдох мэргэжилтэн • Сумын ЗДТГ-ын ХАА холбогдох мэргэжилтэн • Хүнсний ногоо, газар тариалангийн чиглэлийн старт-ап компани • Хүнсний ногооны захын худалдаачид • Хүнсний ногооны үр үйлдвэрлэгчид болон импортлогчид • Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо • Монголын эмэгтэй фермерүүдийн холбоо • НҮБ, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага 	

СУУРЬ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН МЭДЭЭЛЛИЙН САН

ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар дараах үр дүн болон дүгнэлтүүдийг хийсэн байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэл нь орлогын үндсэн эх үүсвэр болж чадахгүй, газар тариалангаас олох орлого хангалтгүй түвшинд байгаа бөгөөд дунд боловсролтой 40-өөс дээш насны эмэгтэйчүүд гол төлөв судалгаанд хамрагдсанаас бүлгийн зохион байгуулалтад хамрагдах түвшин бага байна.

Сумын ногоочдын холбооны үйл ажиллагаа харьцангуй хангалтгүй, газар тариалангийн газар, зоорь, хүлэмжийг зориулалтын дагуу ашиглаж байгаа байдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь 70-аас дээш хувийн ашиглалттай байгаа бол бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа шалтгааны 23.4% техник технологи бүрэн биш, 39.5% санхүүгийн боломжгүй гэсэн шалтгаанууд зонхилж байна. Ашиглахгүй үлдсэн тариалангийн талбайг 38.5%

нь атаршуулж, 5.1% түрээслүүлж 28.2% газар тариалангийн бус үйл ажиллагаанд ашиглаж, 28.2% бусад гэсэн хариултыг өгсөн байна.

Хүнсний ногоочдын хувьд хавар тариалалт үед 29.8% өөрсдийн үрээр, 25.3% хүнсний ногооны үрийн нэгж, 20.1% аймаг, орон нутгийн захаас, 13.2% хүрээлэнгээс үр сонгон хэрэглэж, сонгож авахдаа найдвартай байдал, ургац өгөх чадвар, сортоор (Монголд нутагшсан болон ирээдүйтэй сорт), репродукцаар (элит болон дээд үржүүлгийн үр) гэсэн хүчин зүйлсийг чухалчлан үзэж байна. Хүнсний ногооны үрийн үйлчилгээний нэгж буюу холбооноос баталгаажуулсан, найдвартай, стандарт шаардлага хангасан хүнсний ногооны үрийг тариалангийн талбайдаа нутагшуулах

сонирхол бий эсэхийг тодруулахад 81% сонирхолтой, 35.1% нь Үрийн нөөцийн улсын сангийн тухай мэддэг гэж хариулсан бол эдгээр хүмүүсийн 61,8% нь нэгээс дээш удаа энэхүү сангаас үр авч ашиглаж байжээ.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд орон нутгийн засаг захиргаанаас хүнсний ногооны чиглэлийн сургалтад судалгаанд оролцогсдын 53.8% хамрагдаж, шинэ технологийг агротехникийн үе шатуудад 6.9-11.0% нь нэвтрүүлж, орон нутгийн бордоог 58.4% нь түлхүү хэрэглэж, 52.3% ургамал хамгааллын бодис хэрэглэхгүй байгаа бол, 38.3% нь хортны эсрэг /пестицид/, 24.2% хог ургамлын эсрэг /гербицид/, 4.7% бусад бодисыг хэрэглэж байна.

Дүрс 3. Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэлийн орчны шинжилгээ



"ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД УЛАМЖЛАЛТ БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ АРГЫГ АШИГЛАХ НЬ-3" ТӨСЛИЙН ЭЦСИЙН ШАТНЫ ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Мэрси Кор Монгол ОУБ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Мэрси Кор Монгол ОУБ-ийн хэрэгжүүлсэн "Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь" (LTS-3) төслийн эцсийн шатны үнэлгээний мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэх зорилготой байв. Үүний хүрээнд төслийн баг нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:


- Олон улсад чанарын судалгаанд өргөн ашиглагддаг "Үр дүнгийн ургац хураах" аргачлалыг төслийн онцлог, Монголын нөхцөлд буулган бэлтгэж, үнэлгээний үндсэн аргачлалаар сонгосон.
- Зорилтот орон нутгуудад мэдээлэл цуглуулах төлөвлөгөө гарган, судалгаанд оролцох талуудтай урьдчилан холбогдож, талбарт ажиллах бэлтгэл ажлыг хангасан.
- Зорилтот орон нутгуудад мэдээлэл цуглуулах ажлыг амжилттай зохион байгуулсан.
- Цугларсан мэдээлэлд чанарын хяналт хийж, нэгтгэн, мэдээлэл боловсруулах программд оруулсан.
- Мэдээлэлд шинжилгээ хийж "Үр дүнгийн ургац хураах аргачлал"-ын дагуу холбогдох үр дүнг бэлтгэн захиалагч талд хүлээлгэн өгсөн.



2020 10-р сар

2020 11-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот болон Баян-Өлгий аймаг (Өлгий хот, Алтай сум),
Ховд аймаг (Ховд хот, Эрдэнэбүрэн сум), Хэнтий аймаг (Чингис хот, Баянмөнх сум, Дархан сум),

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Мэрси Кор Монгол (MCM) Олон улсын байгууллага нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн харьяа Гамшигт Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Газар (OFDA) хамтран **“Гамшигийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь”** төслийг 2013 оноос эхлэн зургаан жилийн хугацаанд гурван үе шаттайгаар Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ), Мал Эмнэлгийн Ерөнхий Газар (МЭЭГ), Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ) болон зорилтот бүсүүдийн аймаг сумдын төрийн байгууллагууд, малчин иргэдтэй хамтран хэрэгжүүлээд байна. Төслийн гол зорилго нь гамшигийн эрсдлийн бэлэн байдал болон бэлчээрийн менежментийг сайжруулсанаар малчин өрхүүдийн эмзэг байдлыг бууруулахад оршиж байв.

IRIM судалгааны хүрээлэн нь уг төслийн хэрэгжилтэд эцсийн шатны хөндлөнгийн үнэлгээг 2020 оны 10 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Төсөл нь байгалийн гамшиг буюу ган, зудын эрсдэл, эрс тэс уур амьсгалтай холбоотойгоор олон тооны малын хоргодол

өртөх магадлал өндөр, малын өвчний эрсдэл, бэлчээрийн талхлалт, даац зэргийн ерөнхий төлөв байдлыг харгалзан Баян-Өлгий, Увс, Ховд, Хэнтий, Сүхбаатар аймгуудад хэрэгжсэн. Эдгээр бүс нутгуудаас Хэнтий, Баян-Өлгий, Ховд гэсэн гурван аймгийн зургаан сумдыг сонгон үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн болно.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Улаанбаатар хот болон зорилтот бүсүүдийн холбогдох байгууллагуудын албан хаагчидтай ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага (ФБЯ) төслийн үр шим хүртэгчид буюу малчдын дунд ФБЯ-ыг зохион байгуулсан бөгөөд мэдээлэл цуглуулалтад “Үр дүнгийн ургац хураах” аргачлалыг ашиглалаа.

ҮР ДҮН

IRIM судалгааны хүрээлэн нь зөвхөн мэдээлэл цуглуулах шатанд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үр дүн, тайлан бэлтгэх шатад оролцоогүй. Эцсийн үнэлгээний тайланг олон улсын үнэлээч гүйцэтгэж захиалагч талд хүлээлгэн өгсөн.

МОНГОЛ – АВСТРАЛИЙН НИЙГЭМЛЭГ “MOZZIES”-ИЙН ЗАСАГЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- 2020 оны Эмэгтэйчүүдийн Манлайллын Хөтөлбөрийн ‘Mozzies Rebranding’ төслийн баг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Үнэлгээний зорилго нь Монгол – Австралийн “Mozzies” нийгэмлэгийн засаглал, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, цаашид нийгэмлэгийн чадавхыг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах байв. Энэхүү зорилгын хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

1. Нийгэмлэгийн засаглал, бүтэц зохион байгуулалтын үнэлгээ
2. Нийгэмлэгийн үйл ажиллагааны үнэлгээ
3. Нийгэмлэгийн үйл ажиллагааны цаашдын хэрэгцээ, шаардлага



2020 3-р сар

2020 6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Австрали Улсын Засгийн Газар, Гадаад Хэрэг Худалдааны Яамнаас (ГХХЯ) санаачлан санхүүжүүлдэг, Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрөөс Зориг сантай түншлэн Эмэгтэйчүүдийн Манлайллын Хөтөлбөрийг (ЭМХ) хэрэгжүүлдэг. ЭМХ нь Австралийн Засгийн Газраас Монгол Улсын хөгжилд үзүүлдэг туслалцааны нэг хэсэг бөгөөд 2014 оноос хойш Австрали Улсад магистр болон докторын зэргээр суралцаж төгссөн төгсөгчдийг хамруулан хэрэгжсээр байна. Хөтөлбөрийн 2020 оны оролцогчдоос энэхүү үнэлгээг гүйцэтгэх хүсэлтийг ирүүлсэн юм. Засаглал, үйл ажиллагааг үнэлэх хүрээнд тус нийгэмлэгийн төлөөлөл болох гүйцэтгэх удирдлага, нийгэмлэгийн гишүүд болон хамтрагч байгууллага, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төгсөгчдийн холбооны төлөөллийг хамруулсан.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Монгол – Австралийн Нийгэмлэгийн засаглал, үйл ажиллагаанд өмнө нь хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаагүй учраас харьцуулах суурь дата байхгүй. Тиймээс уг үнэлгээнд нийгэмлэгийн дүрмийг гол баримт бичиг болгон ашигласан. Мэдээлэл цуглуулах болон боловсруулах шатанд дараах холимог аргуудыг ашигласан.

1. Тоон судалгаагаар нэгд, нийгэмлэгийн засаглал, бүтэц зохион байгуулалтын талаарх гишүүдийн мэдлэг, удирдлагын багийн

ажлын гүйцэтгэл, түүний үнэлгээ, бүтэц, зохион байгуулалттай холбоотой өөрчлөх санал; хоёрт, нийгэмлэгийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ, гишүүдийн нийгэмлэгээс хүлээж буй хүлээлт, гишүүдийн хэрэгцээ, шаардлага, тэдний цаашид үйл ажиллагаанд оролцох оролцоог тус тус тодорхойлсон.

2. Баримт бичгийн судалгаагаар, Монгол – Австралийн Нийгэмлэгийн олон нийтэд болон үнэлгээний багт нээлттэй бодлогын баримт бичгүүдтэй танилцаж 4 төрлийн шинжилгээ хийсэн;
3. Чанарын судалгаагаар нэгд, нийгэмлэгийн засаглал, бүтэц зохион байгуулалтад тулгамдаж буй асуудал, учир шалтгаан болон сайжруулах санал; хоёрт, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын засаглал, үйл ажиллагааны сайн туршлага зэргийг тус тус тодорхойлсон.

Үнэлгээний хүрээнд нийт 18 чанарын ярилцлага, 56 тоон судалгааны асуумж цуглуулж, мэдээлэлд боловсруулалт, дүн шинжилгээ хийн захиалагч талд эцсийн тайлан болон холбогдох санал зөвлөмжийг хүргүүлсэн.

ҮР ДҮН

Уг ажил нь тус байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, олон нийтэд чиглэсэн үр дүнг гаргаагүй тул тодорхой мэдээлэл оруулах тохиромжгүй юм.

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ: “ХУВИЙН ХЭВШИЛ БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ” ТУРШИЛТЫН ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь хувийн хэвшил болон их, дээд сургуулийн уялдаа холбоог бий болгох зорилготой бөгөөд судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Хувийн хэвшлийн байгууллагууд болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны тулгамдсан асуудлыг судлах;
2. Зорилтот салбар дахь төгсөгчдийн ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг тодорхойлох;
3. Оролцогч талуудын хамтын ажиллагааны боломжийг тодорхойлох;
4. Байнгын хэлэлцүүлгийн форум бий болгоход туслах замаар, хүний нөөцийг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний чиглэлээр салбараас тодорхойлсон хэрэгцээг шийдвэрлэхэд их дээд сургуулиудад дэмжлэг үзүүлэх;
5. Мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн төлөөлөл болон их дээд сургуулийн төлөөллүүдийн хооронд тогтмол зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.



2020 10-р сар

2021 5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ) “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд оюутнуудад дээд боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх зорилт дэвшүүлжээ.¹ Энэхүү баримт бичигт “хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч ба их, дээд сургуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулах” гэж заасан.

Монгол Улсад жил бүр 25 мянган оюутан их дээд сургууль, коллежийг төгсдөг.² Эдгээр шинэ төгсөгчдөд хамгийн түгээмэл тулгамддаг асуудал нь ямар нэг ажлын туршлагагүйгээр тохирсон ажлын байраа олоход хүндрэлтэй байдаг аж. Нөгөө талаар ажил олгогчид ажил хийх хүсэлгүй, туршлагагүй, ажлын ачаалал даах чадваргүй ажилчидтай болох бэрхшээл үүсдэг. 2019 онд гэхэд л ажлын байранд тохирох чадварлаг боловсон хүчин байхгүйн улмаас 17.7 мянган ажлын байр ажилчдын хомсдолтой байжээ. Зарим их, дээд сургууль хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөтөлбөр боловсруулахыг эрмэлздэг боловч боловсон хүчний мэдлэг, ур чадвараас шалтгаалан хөтөлбөр боловсруулах ажил дутмаг, хангалтгүй явагдаж байна. Төрийн өмчийн тэргүүлэх их, дээд сургуулиудын хувьд аль хэдийн хувийн хэвшлийн компаниудтай хамтран ажиллах санаачилга гаргасан боловч одоогийн чадавч, нөөц нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна. Үүнээс үзэхэд Монгол Улсад хувийн хэвшил болон их дээд

сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа нь харагдаж байгаа юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны төсөл нь (i) Бэлтгэл үе шат, (ii) Судалгааны ажил болон үзэл баримтлал боловсруулах үе шат, (iii) Оролцогч талуудыг холбох, нөлөөлөл, тайлагнах үе шат гэсэн гурван үндсэн үе шаттай даалгаврыг гүйцэтгэнэ. Эхний хоёр шатны үр дүнд IRIM нь хувийн хэвшил болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны нөхцөл байдалд гол анхаарлаа хандуулж цогц судалгааг хийсэн. Ийнхүү мэдээлэл цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, ганцаарчилсан ярилцлага, ФБЯ гэсэн чанарын судалгааны аргуудыг ашиглаж, нийт 70 ганцаарчилсан ярилцлага, 6 ФБЯ хийлээ. Оролцогч талуудыг холбох, нөлөөлөл, тайлагнах үе шатны хүрээнд төслийн баг мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор холбогдох сонирхогч талуудтай цуврал зөвлөлдөх уулзалтуудыг одоогоор зохион байгуулж байна.

ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг боловсруулах явцад хэрэгжиж байгаа ба 2021 оны 05 сард эцсийн үр дүн гарахаар төлөвлөн ажиллаж байна.

1 <https://mecss.gov.mn/page/41/>

2 NSO. Education statistics. 2019

"ОЙТ ХЭЭРИЙН ЭКОСИСТЕМ БОЛОН ХОВОРДОЖ БУЙ АМЬТДЫГ НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХАМГААЛАХ НЬ" ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэгээс Архангай аймгийн Булган сумын Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт оршин суугаа иргэдийн оролцоотой байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жишиг менежментийг бий болгох зорилготой хэрэгжүүлсэн төслийн эцсийн үр дүнг үнэлэхэд уг судалгааны зорилго оршино. Энэхүү үр дүнг үнэлэхийн тулд дараах зорилтуудын дагуу мэдээллээ цуглууллаа. Үүнд:

- Тээлийн ОНТХГ-т оршин суугаа иргэдийн нийгэм-эдийн засгийн байдлыг үнэлэх
- Төслийн үйл ажиллагаа бүрийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх
- Иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагыг үнэлэх гэх мэт багтаж байна.



2021 1-р сар

2021 4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Архангай аймгийн Булган сум

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2018 оны 7 сараас 2021 оны 3-р сарын хугацаанд Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгээс “Ойт хээрийн экосистем болон ховордож буй амьтдыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслийг хэрэгжүүлсэн. Архангай аймгийн Булган сум нь ойт хээрийн экосистемийн төлөөлөл бөгөөд газарзүйн байршлын хувьд Архангай аймгийн Эрдэнэбулган сум буюу аймгийн төвтэй ойрхон байршдаг тул хулгайн мод, хулгайн ангийн хэрэг түгээмэл гардаг ба бэлчээрийн доройтолд өртсөн бүс нутаг болсон нь уг төслийг хэрэгжүүлэхэд тус газрыг сонгох үндэслэл болсон. Төсөл хэрэгжиж эхлэх үед IRIM судалгааны хүрээлэн суурь судалгааг гүйцэтгэж байсан бөгөөд 3 жилийн хугацаанд хэрэгжсэн энэхүү төслийн үр нөлөөг судалж, эцсийн үнэлгээг суурь судалгаатай харьцуулж, үр дүнг тодорхойлох нь тус төслийн гол зорилго байв.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт оршин суугаа иргэдийн нийгэм, эдийн

засгийн байдлыг үнэлж, төсөл эхэлж байсан 2018 онд хийгдсэн суурь судалгааны үр дүн болон улсын, бүсийн, орон нутгийн бусад иргэдийн амьжиргаатай харьцуулах явдал нь жендерийн эрх, тэгш байдлыг хангаж, баталгаат ажлын байрыг бий болгох замаар ядуурлыг бууруулж, өлсгөлөнг зогсоох, эдийн засгийн өсөлтийг бий болгох Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай илүү уялдаатай байв. Суурь болон эцсийн үр дүнг хооронд нь харьцуулахын тулд суурь судалгаанд ашигласан арга зүйг өөрчлөхгүйгээр эцсийн үнэлгээнд ашиглав.

Суурь судалгаанаас ялгаатай нь эцсийн үр дүнг үнэлэхдээ Олон хэмжээст ядуурлын индексэд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох регрессийн шинжилгээ хийсэн. Ингэснээр өрхийн тэргүүний боловсрол, нас, нөхөрлөлийн гишүүн эсэх зэрэг өрхийн онцлогоос хамаарч тухайн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал ялгаатай эсэхийг тодорхойлох боломж бүрдсэн юм. Нутгийн иргэдийн оролцоотой байгаль хамгаалах асуудалд төслөөс үр шим хүртэгчдийн хандах хандлагыг үнэлэхийн тулд судалгааны баг 150 өрхөөс авсан асуулгын өгөгдлийг ашиглан энгийн статистик шинжилгээ, харьцуулсан шинжилгээ,

вариацийн шинжилгээ хийлээ.

Түүнчлэн, энэ хэсэгт баримт, бичгийн судалгаа хийж, төслөөс үр шим хүртэгчийн нөхцөл байдлыг тухайн орон нутгийн бусад иргэдтэй харьцуулан дүгнэлээ.

Төслийн үйл ажиллагаа бүрийн хэрэгжилт, үр нөлөөг логик хүрээний дагуу үнэлж, дүгнэхийн тулд судалгааны баг төслийн баримт бичгүүд, холбогдох материалуудыг судалж, нийт 5 зорилт, 21 шалгуур бүхий логик хүрээний дагуу төслийн үйл ажиллагаа бүрийн үр дүнг тоон болон чанарын судалгааны арга зүй ашиглан үнэлсэн юм.

Анхдагч тоон өгөгдөл

Архангай аймгийн Булган сумын 881 өрхөөс 150 өрхийг түүвэрлэн, судалгаанд хамруулсан ба эдгээр өрхийн 134 нь нөхөрлөлийн гишүүн, бусад нь нөхөрлөлийн гишүүн бус өрх байв.

Анхдагч, чанарын мэдээлэл

Төслийн талаар гол мэдээлэл өгөх иргэд, нөхөрлөлийн гишүүд, орон нутгийн удирдлага, байгаль хамгаалагч зэрэг оролцогч талуудаас хагас бүтэцлэгдсэн ярилцлага авч, анхдагч, чанарын мэдээллийг цуглуулж, нийт 18 ярилцлага хийсэн байна.

Тоон болон чанарын хоёрдогч мэдээлэл

Судалгааны баг тоон болон чанарын анхдагч өгөгдөл, мэдээлэлд шинжилгээ хийхээс гадна дараах хоёрдогч өгөгдөл, мэдээллүүдийг ашиглаж, төслийн эцсийн үр дүнг үнэллээ. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны жилийн болон хагас жилийн тайлангууд
- Хойд Могойн гол – Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө, 2018-2023
- Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт оршин суугаа иргэдийн нийгэм-эдийн засгийн суурь судалгаа, 2018 он
- Төслийн үр дүнг хэмжих үнэлгээ, мониторингийн логик хүрээ
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн статистик мэдээ, холбогдох тайлан

ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бэлтгэх явцад хэрэгжиж байгаа ба 2021 оны 4 сард эцсийн үр дүнг гарахаар төлөвлөн ажиллаж байна.

МОНГОЛ УЛСАД ГАМШГИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Азийн Хөгжлийн Банк

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү Техникийн туслалцааны төслийн зорилго нь Монгол Улсын Засгийн газрын тогтоосон журам, Азийн Хөгжлийн Банкны Хамгааллын бодлого, төсөл хэрэгжүүлэх журам, шаардлагын дагуу Монгол Улс дахь Эрт зарлан мэдээлэх систем (ЭЗМС)-ийг бэхжүүлэх төслийн бэлтгэл баримт бичигт зохих урьдчилсан үнэлгээ хийж, шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэн гаргах явдал юм.

Энэхүү төслийн гүйцэтгэгч агентлаг нь Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) бөгөөд төсөл нь энэхүү байгууллагад дэмжлэг үзүүлэн ажиллана.

Төслийн эхний шатыг хэрэгжүүлэхээр Франц Улсад байрлалтай Консейл Санте, болон түүний хамтрагч SOFRECO байгууллагууд шалгарсан бөгөөд дээрх байгууллагууд нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг IRIM судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байна.




2020

9-р сар

2021

6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот болон 21 аймаг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад тохиож болохуйц, таамаглаж буй бүхий л боломжит гамшгийн үед ашиглах, өгөгдөл мэдээлэл цуглуулах, хуваалцах, дүн шинжилгээ хийх, зарлан мэдээлэх, анхааруулга түгээх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, Зарлан мэдээлэх нэгдсэн системийн загварыг боловсруулан гаргах шаардлагаас үүдэн энэхүү төслийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Техникийн туслалцааны төслийн зорилтууд нь:

(i) Төслийн үр нөлөөг сайжруулах талын жишиг хувилбарыг багтаасан шинэлэг санаа, үзэл баримтлал, менежментийн арга, технологийн шийдлийг тодорхойлон гаргаж, төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж өгөх замаар төслийг АХБ-ны санхүүжилтэд тохиромжтой байдлаар загварчилж баталгаажуулсан төслийн дизайн гаргах;

- (ii) Техник, эдийн засаг, санхүү, засаглал, байгаль орчны болон нийгмийн хамгаалал, ядуурал, нийгмийн болон төслийн эрсдэл, сааруулах арга хэмжээний нарийвчилсан нягтлан шалгах үнэлгээнд үндэслэн санал болгож буй төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хянах;
- (iii) Гүйцэтгэгч байгууллага, хэрэгжүүлэгч байгууллага, тэдгээрийн төсөл хэрэгжүүлэгч нэгж, орон нутгийн байгууллага, болон холбогдох бусад оролцогч талуудыг оролцуулан төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх талын институцийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах;
- (iv) Төслийн үйл ажиллагааг бүх түвшинд зохицуулах;
- (v) Төслийн дизайн, тайлагнах ажлыг чанартай гүйцэтгэх;
- (vi) Ажлын хуваарь, төсөл боловсруулах шатанд гарах үр дүнг тогтсон хугацаанд хэрэгжүүлэх;

(vii) Зээлийн төслийн саналд орох баримтуудыг бэлтгэх ба үүнд ТЭЗҮ-ийн тайлан багтана.

Техникийн туслалцааны төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Техникийн дизайн, төслийг боловсруулж, техник эдийн засгийн үнэлгээ хийсэн байна. Энэхүү ажлын үр дүнд төслийн үйл ажиллагааг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлж, төслийн үйл ажиллагаа нь ойн салбарыг хүртээмжтэй хөгжүүлэх, шилдэг туршлагыг уялдуулахын тулд төслийн техник эдийн засгийн үндэслэл, техникийн дизайны үнэлгээг хийнэ.
2. Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллагуудын техникийн болон төслийн менежментийн чадавх сайжирсан байна. Үүний үр дүнд төслийн бэлэн байдал, төслийн хэрэгжилтийг сайжруулахын тулд гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч агентлагуудын чадавхыг бэхжүүлнэ.
3. Нийгэм, жендер, хамгааллын талаарх үнэлгээний төлөвлөлт боловсруулж бэлэн болсон байна. Үүний үр дүнд төсөлтэй холбоотой нийгмийн болон хамгааллын (нийгмийн болон хүрээлэн буй орчны) зохих шаардлагын үнэлгээ, төлөвлөлтийг бэлтгэнэ.
4. Хэрэгжүүлэлтийн зохицуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны багцыг бэлтгэсэн байна. Үүний үр дүнд төсөл боловсруулахад шаардагдах

нягт нямбай байдлын шаардлагыг хянах, бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

5. КОВИД-19 цар тахлын тандалтын тогтолцоог туршилтаар нэвтрүүлсэн байна. Үүний үр дүнд ОБЕГ, ЭМЯ-ны хоорондын зохицуулалтаар тахлыг эрт зарлан мэдээлэх тогтолцооны нэг хэсэг болох тохирох тандалтын тогтолцоог туршихад туслах болно.
6. Баримтжуулсан төслийн дизайны ноу-хау буюу арга барил. Энэ үр дүнгээр төслийн ерөнхий дизайны тоймыг гаргаж, арга барилыг илүү өргөн хүрээнд үйлчлүүлэгчдэд хүргэнэ.

ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бичих явцад хэрэгжиж байгаа ба 2021 оны 9 сард эцсийн үр дүн гарахаар төлөвлөгдөөд байна. Уг төслийн хүрээнд дараах үр дүн гарахаар ажиллаж байна:

- 2021 оны 1 дүгээр улирал – Зарлан мэдээлэх системийн техникийн үзүүлэлт бүхий мэдээллийг бэлтгэсэн байна;
- 2021 оны 2 дугаар улирал – Санхүүжилт, худалдан авах ажиллагааны зохицуулалтын ажлыг хийж дуусгана;
- 2021 оны 3 дугаар улирал – Цар тахлын тандалтын системийг туршиж, тайлагнана.

УЛААНБУУДАЙ ТАРИАЛАНЧДЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Leibniz Institute of Agricultural Development in Transition Economies

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Герман Улсын хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр дүн шинжилгээ хийдэг IAMO байгууллага нь Монгол Улс дахь улаан буудайн индексжүүлсэн даатгалд хамрагдсан болон хамрагдаагүй нийт 700 гаруй тариалан эрхлэгчдээс даатгалтай холбоотой судалгаа авч байгаа бөгөөд мэдээлэл цуглуулалтын ажлыг манай байгууллага гүйцэтгэж байна.



2020 11-р сар

2021 8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот болон Архангай, Булган, Дархан-Уул, Дорнод Завхан, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл аймгууд

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны арга зүйн хувьд тоон судалгааны аргыг ашиглах ба Судалгааны шийдэл платформоор 700 гаруй тариалан эрхлэгчдээс мэдээлэл цуглуулна.

ҮР ДҮН БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ


Төсөл эхлэлтийн шатанд үргэлжилж байгаа учраас үр дүн гарах харахан болоогүй байна.

Дүрс 1. Судалгаанд оролцогчид



“ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ” (SPACES) ТӨСЛИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН “НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ БА СУУРЬ СУДАЛГАА”

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Монгол Улсын баруун бүсийн сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутгийн хүн амын амьжиргааны өнөөгийн түвшин, тэдгээрийн олон янз байдал, орон нутгийн иргэдийн орлогын гол эх үүсвэр, тулгамдаж буй асуудлыг сум болон өрхийн түвшинд тус тус тодорхойлоход оршино.



2020 11-р сар

2021 8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Баруун бүсийн Баян-Өлгий, Завхан, Увс болон Ховд аймгуудын зорилтот 23 сум

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэн нь “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийн хэрэгжилт явцыг үнэлэхэд ашиглах үр дүнд суурилсан мониторингийн хэрэглэгдэхүүн, систем боловсруулах зөвлөх үйлчилгээг 2020 онд үзүүлсэн. SPACES төсөл нь 4 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд түүний нэг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Нийгэм-Эдийн засгийн шинжилгээ ба суурь судалгаа”-ны ажлыг гүйцэтгэж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Тусгай хамгаалалттай газар нутагт оршин сууж байгаа иргэдийн амьжиргааны түвшнийг сайжруулах замаар экосистемийг хадгалах, хамгаалах нөхцөл боломжийг тодорхойлох нийгэм, эдийн засгийн судалгааны ажлыг баруун 3 аймгийн, зорилтот 22, хяналтын 1 сумын 1660 өрх, 46 орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд, 23 орон нутгийн амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд, 12 иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг хамруулан зохион байгуулна. Судалгааг асуулга, ганцаарчилсан

ярилцлага, ФБЯ, баримт бичгийн судалгаа гэсэн тоон болон чанарын аргыг хослуулан гүйцэтгэнэ. Тоон болон чанарын судалгааны үр дүнг статистик шинжилгээний аргууд болох дан болон харьцуулсан тоололт, хүчин зүйлсийн харьцуулсан шинжилгээ, хүчин зүйлийн шалтгаант хамаарал, үзүүлэлтүүдийн статистик тархалт зэрэг аргуудыг ашиглан шинжилнэ.

Судалгааны аргачлалын тухайд Хүүхдийг ивээх сан, Эф И Джи Консалтинг хамтран боловсруулсан “Өрхийн эдийн засгийн аргачлал (HEA)”-г ашиглан орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг нийгэм, санхүү, хүмүүн, биет, байгаль гэсэн 5 капиталын хүрээнд судалгааны үр дүнг тодорхойлно.

ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бичих явцад хэрэгжиж байгаа ба 2021 оны 06 сард эцсийн үр дүн гарахаар төлөвлөн ажиллаж байна.

“ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ” (SPACES) ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАРИЛЦААНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН “МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГЫН СУДАЛГАА”



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

SPACES төсөл нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийг урт хугацаанд хөгжүүлэх хүрээний нөхцөлийг сайжруулах зорилготой юм. Энэхүү зорилтын хүрээнд байгаль орчны харилцааны бүрэлдэхүүн хэсгийн дагуу Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН)-ийн ажилтнууд болон дотоодын жуулчдын (ялангуяа ТХГН-ээр аялж буй) мэдлэгийг дээшлүүлэх, ТХГН-ийн онцлог шинж чанаруудын талаарх зөв мэдээлэл, ёс зүйн дүрмийн талаарх зөв мэдээллийг сайжруулах зорилготой юм. Мэдлэг, хандлага, туршлагын судалгааны үндсэн зорилго нь:

- Зорилтот ТХГН-д Мэдлэг, хандлага, туршлагын урьдчилсан ба дараах судалгааг хийх, төлөвлөх
- Мэдлэг, хандлага, туршлагын судалгааг байршлын онцлог, статистикийн ач холбогдолтой зорилтот ТХГН-т ганцаарчилсан ярилцлага хийх аргаар зохион байгуулах,
- Мэдлэг, хандлага, туршлагын урьдчилсан судалгааг хийж, ТХГН-ийн онцлог шинж чанар, ТХГН-тай холбоотой мэдээллийн суурь мэдээллийг боловсруулах юм.



2020 9-р сар

2021 10-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар
Орхоны Хөндийн байгалийн цогцолборт газар
Хан-Хэнтийн Улсын Тусгай Хамгаалалттай газар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ) нь 2019 оны 3-р сараас 2022 оны 2-р сар хүртэлх хугацаанд “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь” (SPACES) төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн ерөнхий зорилго нь ‘Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН)-ийн тогтвортой хөгжлийн хүрээн дэх нөхцөл байдлыг сайжруулах’ бөгөөд үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа юм. Энэхүү судалгаа нь SPACES төслийн дөрөв дэх үр дүнгийн хэрэгжилт, үнэлгээг дэмжиж, ТХГН-ийн ажилтнууд болон ТХГН-ийн дотоодын жуулчдын мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахад (Байгаль орчны харилцааны бүрэлдэхүүн хэсгийн дагуу) чиглэнэ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү судалгаанд дотоодын 936 жуулчин, ТХГН-ийн 30 ажилтныг хамруулж, дотоодын жуулчид болон ТХГН-ийн ажилчдын мэдлэг, хандлага, туршлагын өнөөгийн түвшнийг үнэлэв. Мэдээлэл цуглуулалтыг GIZ байгууллагатай анх тохиролцсоны дагуу 2 төрлөөр зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулалтын эхэн үед зорилтот 3 тусгай хамгаалалттай газар IRIM-ын судлаачид биечлэн очиж нийт 418 дотоодын аялагчдаас судалгаа авсан ба үүний дараа 2020 оны зуны 3 сарын хугацаанд эдгээр газар нутгуудаар аялсан нийт 524 дотоодын аялагчдаас утсан судалгаа авсан.

ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бэлтгэх явцад хэрэгжиж байгаа ба 2021 оны 10 сард эцсийн үр дүн гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

“УЛААНБААТАР ХОТ РУУ ЧИГЛЭСЭН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ БА ҮР ДАГАВАР” СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг төсөл нь Улаанбаатар хотын шилжигч өрхийн хүн амын эмзэг байдал болон шилжигч бус өрхийн хүн амын сайн сайхан байдлын талаар дэлгэрэнгүй судалж, Нийслэлийн засаг даргын тамгын газраас 2017-2020 оны хооронд авч хэрэгжүүлсэн шилжих хөдөлгөөний хязгаарлалтын арга хэмжээний үр нөлөөг үнэлэх үндсэн зорилготой. Үүнээс гадна КОВИД-19 цар тахал шилжигч болон шилжигч бус өрхүүдийн амьжиргаанд хэрхэн нөлөө үзүүлж байгааг нэмэлтээр судлав.



2020 1-р сар

2021 5-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн, тэр дундаа хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөнд ардчилсан хувьсгал, нийт улс орныг хамарсан олон удаагийн зуд, уур амьсгалын өөрчлөлт, хөдөө орон нутаг дахь нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, амьдралын баталгаа, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөөр ирсэн. 2005 оноос хойш Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо тогтмол, тасралтгүй өсөж байгаа бөгөөд 2017 оныг хүртэл жилд дунджаар 30,000 иргэн нийслэлд шилжин суурьшсан байна.

Статистикаас харахад хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийн дийлэнх хувь нь нийслэлийн хамгийн их хүн ам бүхий Сонгинохайрхан, Баянзүрх зэрэг захын дүүргүүдийн гэр хорооллын бүсэд суурьшдаг аж. Шилжин ирэгсдийн өсөлтөөс үүдэн тухайн дүүрэг, хорооны нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанар буурах, орчны бохирдол ихсэх зэрэг сөрөг үр дагавруудтай нийслэлийн иргэд нүүр тулдаг байна.


2017 оны 1 сард Нийслэлийн засаг дарга “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийг гаргасан. Уг захирамжийн дагуу 2020 оны 1 сар хүртэл хөдөө орон нутгаас

нийслэл хотод байнга оршин суухаар шилжин ирэх хөдөлгөөнийг зогсоосон. Иймд Нийслэлийн ЗД-ын уг захирамжийн хэрэгжилт, шилжин ирэгсдийн эмзэг байдалд үзүүлсэн нөлөө, МУ-ын дотоод шилжих хөдөлгөөнд гарсан өөрчлөлт зэргийг үнэлэх хэрэгцээнээс үүдэн уг төсөл хэрэгжиж эхэлсэн юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааг тоон болон чанарын арга ашиглан гүйцэтгэсэн бөгөөд судалгаанд УБ хотын төвийн 6 дүүргийн шилжигч болон шилжигч бус нийт 2505 хүн амыг түүвэрлэн тоон судалгааны асуумжаар, мөн шилжигч болон шилжигч бус өрхийн нийт 32 хүнээс чанарын судалгааны бүлгийн ярилцлагаар, гэр хороолол, орон сууц болон холимог гурван хорооны нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэгчид болох өрхийн эмч, цагдаа, халамжийн нийгмийн ажилтан, ЕБС-ийн сургалтын менежер, улсын бүртгэлийн ажилтан зэрэг нийт 15 албан хаагчдаас ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулав. Үүнээс гадна үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны тоон мэдээлэл, шилжих хөдөлгөөний хоригтой холбоотой олон улсын туршлага, судалгаа зэрэгт баримт бичгийн шинжилгээ хийж гүйцэтгэв.

Судалгааны түүврийн ерөнхий бүтэц:



Судалгааны үр дүнг дотоод шилжих хөдөлгөөний цаашдын чиг хандлагыг зохицуулах болон шилжин ирэгсдийн эмзэг байдлыг бууруулахад

чиглэсэн бодлогын санал, зөвлөмж гаргахад ашиглах юм. Судалгааны хүрээнд дараах дөрвөн үндсэн асуултад хариулт олохыг зорьсон.



ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төслийн үр дүнгийн тайлан боловсруулагдаж дууссан ч захиалагч талаас эцэслэх, хэвлэлтэд бэлтгэх үйл ажиллагаа хийгдэж буй тул одоогоор олон нийтэд үр дүнг

тархах боломжгүй байна. Төслийн үр дүнгийн тайлан Англи болон Монгол хэлээр 2021 оны 5 сард хэвлэгдэн гарна.

ОЛОН НИЙТИЙН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг төслийн зорилго нь (а) Засгийн газрын талаарх иргэдийн сэтгэл ханамж, (б) сонгогдсон албан тушаалтнуудын хариуцлагатай байдал, (в) эмэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, (г) Засгийн газрын ерөнхий гүйцэтгэлийн талаарх олон нийтийн санал бодлыг судлах юм. Үүний хүрээнд төслийн баг нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Захиалагч талаас санал болгосон арга зүй, асуумж хэрэглэгдэхүүнийг туршиж, сайжруулах үйл явцыг хариуцан зохион байгуулах
- Зорилтот орон нутгуудад мэдээлэл цуглуулах төлөвлөгөө гарган, утсан судалгааны дата баазыг дотоод мэдээллийн сангаас бүрдүүлж бэлтгэх
- Талбарын мэдээлэл цуглуулалтын ажлыг дуудлагын төвийг ашиглан Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс 2500 өрхийг түүвэрлэн утсан судалгаагаар мэдээлэл цуглуулалтын ажлыг зохион байгуулах
- Цугларсан мэдээллийг зориулалтын программд оруулж, чанарын шаардлага хангасан дата сан үүсгэн захиалагчид хүлээлгэн өгөх
- Мэдээлэлд шинжилгээ хийж, түүний үр дүнд суурилан Аналитик тайлан бэлтгэх
- Судалгааны үр дүнг бүрэн тусгасан танилцуулга (PPT)-ыг бэлтгэн захиалагчид хүлээлгэн өгөх




2020

12-р сар

2021

6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг судалгаа нь нэг цаг хугацаанд өргөн хүрээг хамрах буюу “хөндлөн үргэлжлэх” (cross-section) дизайнтай байна. Үндэсний түвшний энэ судалгаагаар засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг олон нийтийн санал бодлоор тодорхойлох зорилготой юм.

КОВИД-19 цар тахлын хөл хорионы улмаас судалгааны мэдээлэл цуглуулалтыг биечлэн авах боломжгүй байгаа тул судалгааны баг дараах байдлаар түүврийн загварт өөрчлөлт оруулсан.

- Мэдээлэл цуглуулалтыг утсан судалгаагаар зохион байгуулах
- Судалгаанд оролцогчдын холбоо барих жагсаалтыг IRIM судалгааны хүрээлэнгийн дотоод мэдээллийн санд үндэслэн эмхэтгэх
- Түүврийн хүрээг мэдээллийн сангийн нөөц боломжид үндэслэн Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийг төлөөлөхүйц нэмэгдүүлэх

- Мэдээлэл цуглуулалтыг утсан судалгаагаар зохион байгуулахаар болж, зохион байгуулалтыг өөрчилсөн тул түүврийн цэгийг хассан хэдий ч судалгаанд оролцогчдын харьцааг хотоос 69%, хөдөөд 31% хэвээр хадгалж, мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэж байна.

ҮР ДҮН

IRIM судалгааны хүрээлэн нь зөвхөн мэдээлэл цуглуулах шатанд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд үр дүн, тайлан бэлтгэх шатад оролцохгүй болно.

ИД ШИДИЙН ОРОН-2 ОЛОН НИЙТИЙН ТӨВИЙН ОЙРОЛЦООХ ХОРООД ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГЫГ ТАНДАХ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

- Лантуун дохио ТББ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Ид шидийн орон-2 олон нийтийн төвийн ойролцоох хороод дахь олон нийтийн хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, туршлагыг тандан тодорхойлоход оршино. Судалгааны үр дүнг Ид шидийн орон-2 олон нийтийн төвийн хэрэгцээг тодорхойлон, цаашдын үйл ажиллагааг төлөвлөхөд ашиглана.



2021

3-р сар

2021

12-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүргийн 10,
23, 28-р хороо



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ид шидийн орон-2 хүүхэд хамгаалал, хөгжлийн төв (ХХХТ) нь эрсдэлт хүүхдүүдийг хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, зорилтот бүлэгт нөлөөлөх зорилготойгоор 2019 оны 11 сарын 23-нд Баянзүрх дүүргийн 23-р хороонд үүд хаалгаа нээсэн хүүхэд хамгаалал, хөгжлийн төв юм. Тус төвийн байрлаж буй хэсэг нь хүн ам их ихтэй, амьжиргааны түвшин доогуур өрхүүд олон байдаг тул хүүхдийн эрхийн зөрчил тасардаггүй. Тиймээс энэ төвийн ойролцоох хороод дахь олон нийтийн хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, туршлагыг судлах нь үйл ажиллагаагаа үр дүнтэй чиглүүлэхэд туслах бөгөөд энэ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр IRIM судалгааны хүрээлэн нь Ид шидийн орон-2 ОНТ-тэй 2020 оны 10 сарын 03-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд энэ төслийг манай байгууллага нийгмийн хариуцлагын нэг хэсэг болгон хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Энэхүү судалгааг хоёр байгууллагын төлөөлөл бүхий хамтарсан судалгааны баг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд эхний байдлаар Ид шидийн орон-2 олон нийтийн төвийн үйл ажиллагааг үнэлэх “Хяналт-Шинжилгээ үнэлгээний хүрээ”-г боловсруулаад байна. Уг хүрээнд үндэслэн тус ОНТ-ийн ойролцоох хороодод төвийн үйлчилгээнээс үр шим хүртэгчид болон иргэдээс хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага,

туршлагын судалгааг гүйцэтгэнэ. Мөн судалгаанд ОНТ-ийн үзүүлж буй үйлчилгээний хэрэгцээ, танигдсан байдлыг судлан, эдгээрт үндэслэж, төвийн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө, бодлого, стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх юм.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг хоёр байгууллагын хамтарсан “Шинэ салхи” хөтөлбөрт шалгарсан 81 оюутан, залуучуудын оролцоотойгоор зохион байгуулна. Энэ хөтөлбөрийн зорилго нь шинэ, залуу үеийнхнийг хүүхэд хамгааллын болон судалгааны мэдлэг, ур чадвар, практик туршлагатай болгох замаар Ид шидийн орон-2 төвийн зорилтот хороодод өөрийн биеэр судалгааны ажилд оролцох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтэд зохион байгуулахад оршиж байна. Хөтөлбөрийн үр дүнд дээр дурдсан салбарын мэдлэг, ур чадвартай болохоос гадна Лантуун дохио ТББ-д сайн дурын гишүүнээр элсэх, хоёр байгууллагын хамтарсан тодорхойлолттой болох зэрэг боломжуудыг олгож байгаагаараа онцлог юм.

ҮР ДҮН:

Судалгааны талбар дахь мэдээлэл цуглуулалт КОВИД-19 цар тахал дотоодод бүртгэгдсэнтэй холбоотойгоор хойшилж, хүлээлгийн төлөвт байна. Халдварын нөхцөл байдал тогтворжих үед талбарт мэдээлэл цуглуулах ажлыг Ид шидийн орон-2 ОНТ-ийн ойролцоох 3 хороодод хэрэгжүүлэхээр төлөвлөд байна.

БУСАД ТӨСЛҮҮД

№	Төслийн нэр	Захиалагч	Хэрэгжсэн хугацаа
1	Чойр-Сайншандын 220 Кв цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн Байгаль орчин, нийгмийн суурь судалгаа	Ви Эс Эткинс Интернейшнл болон Састэйнабилити Ийст Эйжия	2020 оны 4-р сар
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгаа	Хууль зүй дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Азийн хөгжлийн банк (АХБ)	2020 оны 7-р сараас 2020 оны 11-р сар
3	Онцгой байдлын үеийн зайны сургалт (Теле хичээл)-ын үр дүн, тохиромжтой байдлын үнэлгээ	НҮБ-ын Хүүхдийн Сан	2020 оны 4-р сараас 2020 оны 9-р сар
4	Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ БАГЦ 3-2020	Тогтвортой Амьжиргаа - 3 төсөл	2020 оны 7-р сараас 2020 оны 9-р сар
5	Монгол Улс дахь хүний наймааны нөхцөл байдал, нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа	Олон Улсын Шилжилт хөдөлгөөний байгууллага	2020 оны 4-р сараас
6	“ТББ-ын тухай хуулийн аналитик дэмжлэг” төсөл	Бүгд Найрамдахчуудын Олон Улсын хүрээлэн	2020 оны 4-р сараас 2020 оны 7-р сар
7	Туслах малчдын нийгэм, эдийн засгийн байдал хүний эрхийн хэрэгжилт	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс	2020 оны 8-р сараас 2021 оны 2-р сар